

## JOURNAL OF ARTS AND CULTURAL STUDIES IN MONGOLIA

### АЛТАЙ УРИАНХАЙН БАРУУН АМБАН БУЮУ ДАРХАН ГҮН БАЛДАНДОРЖИЙН ТҮҮХ БОЛОН АМАН УЛАМЖЛАЛЫН ДҮР

Ондршей Срба\*

**Abstract.** The aim of this article is to show two complementary views of a lesser known banner governor of the Mongolian Autonomy period, Baldandorji güng of Altai Uriankhais. I bring together the scarce archive mentions available in Mongolian archives and compare them with the steadily disappearing local oral tradition. The comparison of the archive and the oral evidence proves that the oral sources make possible to approach the significance of the personality for the local community.

**Key words.** Altai Uriankhai, Banner of Darqan güng (Darqan beyise), Baldandorji güng, Čültüm da lama, Altai Frontier, oral history, oral tradition

#### Оршил

Алтай Урианхайн Баруун амбаны хошуу буюу Олноо өргөгдсөн Монгол Улсын үеийн нэрийдлээр Дархан гүний хошуу (1916 онд хэргэмийг залгамжилсан Жамьянжав ноёноос эхлээд Дархан бэйсийн хошуу гэж нэрлэсэн) нь хүн ам, сумын тооны хувьд томоохон хошуудын тоонд ордог байжээ. Хорьдугаар зууны туршид Алтай Урианхайн хүн амын нэлээдгүй хэсэг нь уг нутаг усаа орхин Монгол Улсын төв суурин газар, аймаг хошууд руу нүүн шилжиж, өнөөгийн байдлаар уг нутагтаа хэвээрээ үлдсэн Алтай Урианхайчуудын дийлэнх хэсэг нь (одоогийн Ховд аймгийн Мөнххайрхан, Дуут, Баян-Өлгий аймгийн Булган сум) Баруун амбаны хошууны үр удам болно.

Баруун амбаны хошууны хуучин нутаг одоогийн Булган голын дээд урсгал (аман мэдээгээр Баянголын ам хүртэл), Гурван Цэнхэрийн нутгийг төдийгүй, одоогийн БНХАУ-ын Шинжаан Уйгар Өөртөө Засах орны Чингэл (Цэнгэл) шияны хойд хэсгийг хамарч байсан.

Олноо өргөгдсний үе хүртэл Чингэл голын газар тус хошууны үндсэн төв байсныг орон нутгийн аман түүх болон орчин үеийн эрдэмтэд<sup>1</sup> удаа дараа

<sup>1</sup> Аман түүхийн мэдээлэл хангагчдаас энэ явдлыг юуны өмнө Ховд аймгийн Мөнххайрхан сумын

\* Ондршэй Срба. БНЧех улсын Брно хотын Масарикийн Их сургуулийн Гүн ухааны факультетийн Хэл шинжлэл, Балт судлалын тэнхим

баталж байжээ. Чин улс, Орос улс хоёрын хил хязгаарыг сэргийлэн бататгах зорилгоор Алтай Урианхайн нутгийн баруун өмнөх хэсэгт Алтайн хязгаар гэсэн тусгай засаг захиргааны нэгж байгуулах оролдлого 1886 оноос эхэлж 1904 он хүртэл үргэлжилсэн. 1904 онд Си Хэн (Xi Heng 錫恒) Ховдын амбаны туслагч амбан болсноор, Алтай нурууны өмнөх хэсэг нь биеэ даасан захирагчтай болсон бөгөөд 1906 оноос тус амбан Ховдоос Алтайн Шар сүмд шилжээд Чин улсын Засгийн газарт Ховд, Алтайн хязгаарыг хоёр захиргааны нэгж болгож хуваах санал айлтгасан байна<sup>2</sup>. Тиймээс Алтайн Урианхайн долоон хошуу, Булган голын Торгуудын хоёр хошуу болон Хошуудын нэгэн хошуу нь Алтайн хязгаарт захирагдах болов. 1912 онд энэ тушаалыг Торгуудын Палта ван хаах болсон бөгөөд мөн онд Ховд хот Богд хаант Монгол улсын цэргээр чөлөөлөгдсөн тул тус тушаалын нэр албан ёсоор Алтай уулын хэрэг шийтгэх дарга түшмэл болж хувиржээ.

1906-1913 оны хооронд Алтайн Урианхайн 7 хошууны хуучин нутгийн дундуур буюу Алтайн нуруугаар шинэ хилийн шугам тавигдсны улмаас Алтайн нурууны баруун өмнөх хэсэг Дундад Улсын Засгийн Газарт харьяалагдаад, Алтайн нурууны зүүн хойд хэсэг Дөрвөдийн Баруун гарын Үнэт Зоригт хан аймгийн чуулган, Баруун хязгаарын илбэн тохинуулах сайдын газар, Ховдын сайд - цаашилвал Их Хүрээний Засгийн Газарт харьяалагдах болсон.

Тийм боловч, Олон Улсын төрийн харилцаанд баримтлах байр сууриа тодорхойлж ядан хошууныхаа эрх ашгийг хамгаалахуйц нөлөө багатай байсан Алтай Урианхайн ноёд 1912 оноос 1930-аад он хүртэл Дундад Иргэн Улс, Богд хаант болон Ардын Засгийн Монгол Улсын хоёр талыг баримталж, удаа дараа харьяаллаа сольж дагаар орж байсны эцэст 1930 онд Дархан бэйсийн хошууны төр барьсан төлөөлөгчид цөмөөрөө Алтайг давж Чингэл гол уруу шилжсэний улмаас тус хошууны аливаа данс хар Чингэл голд очиж дагалдах түүхийн үйл явдлын дунд устгагдсан байна.

Ийм учраас, 1930-аад оны засаг захиргааны өөрчлөлт шинэчлэлтийн өмнөх үед холбогдох тус хошууны өөрийн архив, данс эвхмэл бүрмөсөн алга болсон тул холбогдох мэдээ баримтыг зөвхөн Алтай Урианхайн бусад хошуу (юуны өмнө харьцангуй баялаг сан хөмрөгтэй Ёст бэйсийн хошуу) болон дээд шатны төрийн байгууллагуудын фондоос мэр сэр олдож болно.

Дархан бэйсийн хошууны ноёдоос олны дунд алдаршсан ноён бол Чүлтэм да лам (1886–1944?). Чүлтэм да ламын тухай цөөн бус эрдэмтэн судлаач өгүүлэл, товч дуртгал нийтлэсэн боловч, түүний намтрын зарим хэсэг тодорхой бус, түүний төрийн үзэл бодлын тухайд битүүлэг хэвээрээ байсаар байна<sup>3</sup>. Ямартай ч Олон Улсын харилцааны байдал, төрийн чиг хандлага хурдан өөрчлөгдөж байсан тэр үед зах хязгаарын нэгэн хошууг захирсан ноёны хувьд Чүлтэм да лам

Банзарын Ханджав, Баян-Өлгий аймгийн Булган сумын Р.Чадраабал нар чухалчилсан. Түүх судлаач нараас үүнийг голдуу Камимура Акира газрын зургийн судлагааны үр дүнгээр батласан (Камимура Акира 2015).

<sup>2</sup> Үүний тухай дэлгэрэгүй Гантулга 2000, Bao Bin 2013.

<sup>3</sup> Ганболд 2006, 2014, Жаргалсайхан 2012, Камимура Акира in Сүхбаатар – Бямбажав 2015.

юунь  
шаш  
эсэх  
бодл  
Б  
нь Ч  
чухал  
амьд  
чана  
гурва

1)

2)

3)

Б

хошу  
дарга  
хошу  
орох  
ному  
гуйж  
тамга

Б

Хүрэ  
захир  
Дото  
олго  
хүртэ  
дарга  
“хүнд

цол,  
хэргэ  
хошу  
цутгу  
Очир

1)

адил  
нь 20

<sup>4</sup> М  
өр

<sup>5</sup> А-

<sup>6</sup> А-



юуны өмнө өөрийн албат болсон Урианхай ардын эрх ашиг, хошуу нутгийнхаа шашин төрийг хамгаалах зорилгын үүднээс аль талыг баримтлах нь тохиромжтой эсэхийг бодсоны эцэст Чүлтэм да лам өөрийн ах Балдандоржийн төрийн бодлогыг уламжлан авч хэрэгжүүлсэн аж.

Балдандорж бол Чүлтэм да ламын төрсөн ах, хошуу нутаг удирдсан цаг нь Чүлтэм да ламаас богино боловч нутгийнхаа аман уламжлалд бас эрхэм чухал байр суурь эзэлдэг хүн. Архивын эх сурвалжаас, Балдандоржийн хувийн амьдралын тухай мэдээлэл, түүний зан байдлын онцлог, засаглалын өвөрмөц чанарыг мэдэх аргагүй байна. Балдандорж ноёны тухай дурдсан баримтууд гурван зүйлийн агуулга өгүүлж байна. Тодорхойлвол

- 1) 1912 онд Алтайн Урианхайн баруун гарын гурван хошуу Монголын тулгар төрд дагаар орсон тухай,
- 2) Казахууд Урианхайчуудыг дээрэмдэж байсан тухай,
- 3) Дархан гүний хошуу Алтай шан уулын харьяанд орсон тухай бичдэг.

**Балдандорж ноёны тухай архивын баримт:** Сул амбан Балдандоржийн хошуу Монголын тулгар төрд дагаар орсон нь: Алтай Урианхайн бүгдийн дарга Балдандоржоос харьяат хошуу ба хамт зөвлөн тогтсон баруун гарын хоёр хошууны бүгдийн дарга Очиржав, Гомбожав нарын гурван хошуу бүгдээр дагаар орохыг Баруун хязгаарыг сэргийлэн батлах сайд, дэд сайд Зоригт бэйс болон номун хаан Жалханз хутагт нарт 1912 оны 10 дугаар сарын 8-д илгээсэн бичгээр гуйж мэдүүлжээ. Үүний дараагаар Балдандорж ноёныг Дархан цол, гүний хэргэм тамганы хамтаар шагнасан байна.

Баруун гарын бусад хоёр хошуу Манжийн үед өөрийн гэсэн тамгагүй, Их Хүрээнийн Засгийн газарт дагаар орсны хойтон жил нь өөр өөрийн хошууг захирах тамга олгуулахыг гуйжээ<sup>4</sup>. 1913 хаврын сүүл сарын 15-нд [1913.4.21.] Дотоод яамнаас айлтгасан ёсоор тус хоёр хошуунд тамга үйлдүүлэх зөвшөөрлийг олгов<sup>5</sup>. Үүнээс гадна, дагаар орсон үед Гомбожав, Очиржав хоёр огт хишиг хүртээгүй, Балдандорж ноёнттой зөвлөлдөж түүгээр учрыг гаргаж, хоёр хошууны даргад Алтайн Урианхайн Зүүн гарын Сэндэнжав, Төрбат хоёр ноёнттой адил “хүнд зузаан хишиг” шагнахыг гуйсан тул Дотоод яамнаас Гомбожавт Саруул цол, Очиржавт Ёст цол, хоёуланд нь туслагч гүнгийн зэрэг олгуулсан байна. Энэ хэргээр гүн Балдандорж урьд өөрийн нь захиргаанд харьяалагдаж байсан хоёр хошууны ноёныг идэвхтэй дэмжиж өгсөн билээ. Өөрийн түшмэлүүдээр шинээр цутгуулж бүтээсэн тамгийг Саруул гүн Гомбожав 4 дүгээр сарын 12-нд, Ёст гүн Очиржав 5 дугаар сарын шинийн 3-нд хүлээн аваад албаны газраа залжээ<sup>6</sup>.

1914 онд Монголын төрд тусласан учир Баруун хязгаарын бусад ноёдын адилаар түүнд шагнал өгөв. Балдандорж ноён, нийт “Монголын үнээ 10 (үнэ нь 200 лан), иргэн хонь 16 (үнэ нь 64 лан), эм хонь 34 (үнэ нь 68 лан), цагаан

<sup>4</sup> Монгол улсын Үндэсний төв Архив (цаашаа бичээгүй), А-141, Д-1, ХН-5, нугалбар 8, Олноо өргөгдсөний (цаашаа ОӨ) 2 дугаар оны 6 сарын 28-нд. (1912.10.08.)

<sup>5</sup> А-128, Д-1, ХН-3, хуудас 142г-146v, ОӨ 3-дугаар оны 5 сарын 14. (1913.06.23.)

<sup>6</sup> А-128, Д-1, ХН-3, 187г-190v, ОӨ 3-дугаар оны 6 сарын 15 = 1913.7.18.

гурил 50 жин (үнэ нь 6 лан), мөнгө 563 лан гаруй” хэмжээний хандив гаргасан тул түүнийг Улсад туслагч гүнгийн хэргэмд хоёр нэмсэн зэрэг, хоёр тэмдэглэсэн зэрэг шагнасан байна<sup>7</sup>.

Гүн Балдандоржийн үеийн Алтайн Урианхай, Казахын харилцаа: Алтай Урианхайчууд Чин улсад дагаар орж долоон хошуу нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд тогтносны дараа 19 дүгээр зууны эхний хагаст тэдний суурьшин буй нутагт Казах ард түмэн нүүн ирж суурьшиж эхэлсэн байна<sup>8</sup>.

Алтайн Урианхайн долоон хошууны дундаас хамгийн зүүн захын хошуу болох Баруун амбан буюу Автономитын үеийн Дархан гүний хошуунд Казахын нүүдэл бусад хошуунаас харьцангуй хожмын үед хүрсэн гэдэг боловч архивын баримт алдагдаснаас болоод тодорхой мэдээ байхгүй байна.

Тус хошууны аман түүхэнд Казахыг анх орч ирэхэд хошуу ноёд тэд нарт гурван зүйлийн болзол тависан гэнэ. Чингэлийн аман уламжлалаас тодруулвал:

Хойт голын экэн Билүүт, Хужирт гэдэг газарт Ах сумны Цагаа гэдэг занги байж тэр күмнээс энэ Бууршинаас [= Бууржинаас] Чиравайгар [= Шыбарайгыр] Көкөөн тайж гэдэг күмн таван настай бор алаг (борлог) хурдан морио авчираад гэрийн нь бүсээс уяад: “Ахаам, бид нутаг дүрвээд ирвэй, ядарвай. Буур өгтөн”, гэхээр гурван шаардлагаар болгосон болж байна: “Болна, чи ав, буур өгье. Ганцхан галын[х]ээ оронд жилийн нэг галын оронд нэг гунан ирэг шуу өгнөч - энэ нэг [шаардлага], хоёр: чулуун тулга тулагшич [= тулах биш, тулж болохгүй], [тийм эс бол] хойно нь чи чулуун тулга гэхээр энэ миний газар гэнэч, булаалднач. Гурав нь: үхсэн күмний яасыг Өрөнгө голаас цаар [= цааш] тавинач. Тэрнээс наар Касак күм яс тавикш [= тавихгүй]. Гурван шаардлага өгөөд тэгээд буур өгсөн”<sup>9</sup>.

Баян-Өлгийн аймгийн Булган сумын Улаан хус багын өндөр настан Р.Чадраабалын мэдээгээр, түүний өвөг аав, хошууны хүнд болон захирагч хийсэн Сампил “Хаврын цагаар Казахаас голомтын гунан бод хураадаг байсан” гэнэ. Энэ дүрмийн бэлгэдлийн цаад утгийг нь асуувал, гал голомтын доогуур өвс шатдаг бэлчээр ашигласны татварыг гэрийн голомтоор боддог байв<sup>10</sup>. Одоогийн Баян-Өлгий аймгийн Булган сумын Алтай Урианхайчуудын мэдээгээр 1930-аад он хүртэл Казах хүн Булган голд нутаглах явдал их ховор байжээ.

Балдандорж ноёны хошууг захирсан үед холбогдох архивын баримтаас үзвэл, 1913 оны 8 дугаар сарын 14-д “Чингэл голын бэлчир хэмээх газарт байсан тус хошууны лам хүрээний зөөр (хурааж хуримтлуулсан зүйлс) тавьсан газарт Хасагийн хоёр зуун хүн зэвсэг барин хүрч ирээд сахисан хүн нарыг буудан хөөж бурхан номыг бүрнээ эвдэн шамшуулж бүхий тавьсан эд юм ба, бурхан

<sup>7</sup> А-146, Д-1, ХН-1, хуудас 416г-417г, Баруун хязгаарыг сэргийлэн тохинуулах сайдын тушаалын огноо ОӨ 4-р оны 9 сарын 14 = 1914.11.1.

<sup>8</sup> Алтай Урианхайн хошуунд анх удаа Казах хүн орж ирсэн тухай баримт бол 1838 оны бичиг. М-163, Д-1, ХН-4а.

<sup>9</sup> 2013 оны 1 сарын 20-д Шинжаан, Алтай хот, Чингэл шияны төв, Зандваан Мажиг, Какааны Бэкээн/Батцагаантай ярилцсан дуун бичлэгийн нэгдүгээр хэсэг, Батцагааны хэлсэн үг (35:00-36:25 минутад), зохиогчийн хувийн архив.

<sup>10</sup> 2015 оны 5 сарг тэмдэглэсэн аман мэдээгээр.

номь  
бууд  
хөрө  
ба Х  
газр  
гомд  
хүрч  
хохи  
явдл  
хязга  
эсрэг  
хөнг  
гары  
Бару  
хута  
чин  
К  
ард  
Балд  
бие  
төлө  
Шөв  
хүн  
хори  
цөөн  
газр  
тул  
өгөв  
Д  
хан

<sup>11</sup> А-

<sup>12</sup> Ө-

гү

Х

нэ

хо

са

ар

цу

ба

яа

нэ

өр

3-

<sup>13</sup> А-

номын хэрэгслэлийг дээрэмдэн авч, мөн шөнө нутгийн захад жаран буугаар буудаж, хуяг Бажуунаг нарын арван илүү өрхийг дайчлан байхул хогшил хөрөнгийг дээрэмдэн авсан”. Мөнхүү сарын 18-нд “Булган гол дахь түшмэл нар ба Хужиртын Хүрээний сэргийлэн суугаа цэргийг захирах тайж Данзан нарын газраас өргөсөн бичигт, Казахын талаас олон удаагийн малын хулгайн тухай гомдол гаргаад “бас Хойт Сэнхэр голд байсан ардад Хасагийн цэрэг давхин хүрч ирээд бүгд наян илүү өрхийг дайлан сөнөөж, далан илүү хүний амийг хохируулаад тэдний гэр, мал хогшил хөрөнгийг нэгмөсөн авч явсан” гэсэн явдлыг мэдүүлэв. Энэ хоёр яаралтай мэдээг Балдандорж амбан тэр даруй баруун хязгаарыг тохинуулах цэргийг захиралцах сайдад дамжуулж өгөөд Казахын эсрэг улсын цэрэг явуулахыг сануулсан”<sup>11</sup> байна. Энэхүү хэргийг амбаны газрууд хөнгөнөөр үзээгүй харин 1913 оны 7 дугаар сарын 27-нд Дөрвөдийн баруун гарын Үнэн зоригт хан аймгийн чуулган даргын жасаанаас эл хэргийг цаашаа Баруун хязгаарыг тохинуулах цэргийг дайчлан захирах сайд Хатанбаатар, ноён хутагт Дамбийжанцан, баруун хязгаарыг тохинуулах цэргийг захиралцах сайд чин ачит бэйл Гончигдамба нарт уламжлан мэдэгджээ<sup>12</sup>.

Казахын хулгай дээрэм түүгээр зогссонгүй үргэлжилсэн болохоор хошууны ард олон ихэд ядуурсан тул 1914 оны 9 дүгээр сарын 14-нд Дархан засаг гүн Балдандорж алба зүйлийг хөнгөлөхийг гуйжээ. Тус бичигт Балдандоржийн бие өвдсөн тул сайдын газарт биеэрээ бараалхаж үл чадах явдлыг илэрхийлж төлөөний түшмэлээр дэд да лам Лувсанжанцаныг явуулав. Тус хошууны хүнд Шөвгийн мэдүүлэн ирснээр (02.09.1914) Хойчулуун гэдэг газарт “олон морьтой хүн айлын гадна хүрч ирэн буугаар буудаж манай хэдэн өрхдийн хогшил тэмээ хорин тав, их бага адуу жаран зургааг дээрэмдэн аваачсан нь өчүүхэн бидний хүн цөөн зэвсэггүй учирт хөөн нэхэж чадсангүй” хэмээн мэдүүлж, “хошууны тамгын газраас хулгайч нарыг Казах Монгол алийг ч тодорхойлон чадахгүй байсан тул тус хэргийг цаашаа сурвалжилахаар хамаарсан чуулганы даргад уламжилж өгөв<sup>13</sup>.

Да лам Лувсанжанцан Дөрвөдийн сайн заяат баруун гарын үнэн зоригт хан аймгийн хамаарсан чуулганы даргын яаманд 1914 оны 9 дүгээр сарын

<sup>11</sup> А-128, Д-1, ХН-3, 266г-267в. ОӨ 3-дугаар оны 7 сарын 27-д = 1913.8.28.

<sup>12</sup> Өдгөө манай Дөрвөдийн баруун Үнэн зоригт хан аймгийн Алтайн Урианхайн баруун гарын гүнгийн зэрэг бүгдийн дарга Балдандоржийн хошууны ардуудыг тэрслэнгүү дээрэмчин Хасагууд удаа дараа дайлан дээрэмдэж тэдний хошууны тавин илүү хүний амийг шоглож нэгэн зуун илүү өрх ардын хөрөнгө эд малыг цөлбөн дээрэмдэж хохируулан сүйтгэсэн тул тэр хошуу сарнин хошуу хэвийг алдаж баримтлах нэрийдэх газаргүй болжухуй хэмээмүй. Тухайд санаваас гүн Балдандоржийн хошууны тэр мэт дайчлагдан дээрэмдэж маш гацагдан үгүйрсэн арад нар одоо амь сүлжиж хошуу сум болон сууж чадах арга үл олон үнэхээрийн мохож цухалдан сарнин тархаах нь илэрхий болох тул, олвоос сайд Зоригт бэйл танаа өргөн мэдүүлэх байцаан толилож тийнхүү өлбөрөн цухалдаж сарнин тархаах туйлд хүрсэн боолчууд олныг яахин хураамжлан тэнхрүүлж дэгжүүлэн хүмүүжүүлхийг заан тушаахыг гуйхаас гадна, үүнийг нэгэнтээгүүр сайд хатанбаатар бэйс, сайд ноён хутагт, сайд чин ачит бэйл танаа нэгэн адил өргөн мэдүүлсэн явдалыг хамтаар гаргаж үүний тул өргөв. А-128, Д-1, ХН-3, хуудас 279г-в. ОӨ 3-дугаар оны 7 сарын 27-д = 1913.8.28.

<sup>13</sup> А-141, Д-1, ХН-75, н. 1. ОӨ 4-р оны 8 сарын 20-д = 1914.9.10.

30-д хүрээд өмнөх 1913 оны 8 дугаар сарын 7-оос тус хошууны Хойт Цэнхэрт нутаглаж байсан зуун арван нэгэн өрхийг Казах хулгайч нар удаа дараагаар дайрч хэлмэгдүүлдэг нийт 64 хүнийн мал шоглогдсон гэж мэдүүлэв.<sup>14</sup> (Энэ үетэй холбогдох түүхийн нэгэн үйл явдлыг дээр дурдсан Булган сумын Р. Чадраабал гуай өгүүлсэн буй.) Түүний өвөг аав хошууны хүнд болон захирагч явсан Сампил Булган голд нийлдэг Түргэн голын баруун талын цутгалан устай Гүрт гэдэг урт салаанд хаваржиж зусдаг байсан. Нэг удаа Казахын их аюултай дайн дажин болоод Сампил төрөл садныхаа хамтаар Гүртийн салаанд хоргодон ороод тус салаанд нэг хавцал замаас өөр орох замгүй тул тэнд өөрийгөө хамгаалан ямар ч хорогдолгүй гарч чадсан ажээ<sup>15</sup>.

Ховд хотыг чөлөөлөх явцад Баруун хязгаар дахь хятад худалдаачдын аюулгүй байдал төвшин бус болсонд Дархан гүний хошууны нутагт худалдаалан суусан хятад худалдаачин “иргэн” Наст зэрэг иргэд 1912 онд “цагийг дагаж зугтан одоход” тэдний тус хошууны хүрээний газарт нийлүүлдэг гурил, будаа, тариа зэргийн эд барааг эзгүй орхисон тул хошууны харьяат газрын ойр хавийн хүмүүс хуваан хэрэглэснийг 1912 оны өвөл Баруун хязгаарыг сэргийлэн батлах сайдын яамнаас уул юмыг төлүүлэхээр шаардаж, нийт 323 лан мөнгийг хошуунаас гаргуулжээ<sup>16</sup>.

**Дархангүний хошуу Алтай шан уулын харьяанд орсон тухай:** Олноо өргөгдсний дөрөвдүгээр оны найман сард (1914 оны 9, 10 сарын зааг) Баруун хязгаарыг сэргийлэн батлах сайд “нийлэн хэлэлцэж зах хязгаарын хошуудыг тохинуулах чухал хэргийг зөвлөн шийтгэх” зорилгоор Торгууд, Хошуудын ноёд болон Алтай Урианхайн Дархан гүн Балдандоржийг Ховд руу яаралтай дуудуулсан байна.

Ноёдуудад чимээ дамжуулахаар зарагдсан элч түшмэл Соном, Гомбожав нар Торгуудад очихоор явах замд цэрэг Балдангомботой учирсанд “Торгууд ноёдыг тамганы хамт баруун этгээдээс хятад, монгол цэрэг ирж хавчин аваачсан” гэсэн мэдээг дуулгав. Балдангомбо хятад цэргээс зугтаж гарч ирсэн гэсэн. Хоёр элч тус мэдээдээс айн эмээж замд байсан Захчины Итгэмжит бэйс Цэрэндоржийн хошуун (одоогийн Үенч сумын нутаг)-д түр саатаж, Захчины Төвшинийг Торгуудын газарт байдалтай нь танилцхаар илгээв. Тэд Торгууд бэйл Магсаржавын туслагчтай уулзаж Өрөмчийн ду танг (都堂)-аас цэрэг ирж, Монголоос олгосон тамгыг хурааж авав гэсэн мэдээ үнэн гэдгийг мэджээ. Иймээс мэдээг хүргүүлэвч Торгуудын ноёдоос чимээ сураггүй байв. Хоёр элч цаашаа Булган гол өгсөөд Балдандорж амбанд мэдээ хүргүүлсэн боловч тэр бие өвчтөй байсан тул явж үл чадна гэсэн учрыг мэдүүлэв<sup>17</sup>. Балдандорж Ховд руу төлөөний түшмэлээ явуулжээ<sup>18</sup>.

<sup>14</sup> А-128, Д-1, ХН-3, хуудас 314г-в. ОӨ 3-р оны 8 сарын 13 = 1913.9.13.

<sup>15</sup> 2015 оны 6 сарын 2-нд тэмдэглэсэн аман мэдээгээр.

<sup>16</sup> А-146, Д-1, ХН-1, хуудас 179г-180в. ОӨ 4-р оны 8 сарын 11-д тушаасан бичиг = 1914.9.30.

<sup>17</sup> А-146, д-1, ХН-1, хуудас 382г-384г, ОӨ 4-р он 9 сар (өдрийг заагаагүй).

<sup>18</sup> А-141, Д-1, ХН-74, нугалбар 2. Алтай Урианхайн сул сайд гүн Балдандоржоос харьяат хошууг

19  
Хиагт  
өгсөг  
хэвэ  
гүнг  
гүн  
ирэх  
/  
1916  
мэдэ  
байс  
харь  
зудь  
ард  
奇台  
нута  
татг  
учир  
бачи  
Хэри  
хэрэ  
ямаг  
найр  
зогс  
сонс  
уулз  
батл  
Уг ё  
мэду  
сайд  
мэде  
хязг  
уруу  
“тан  
улсь  
байг

хг

о)

=

19 А

20 А

Б:

сг



1914 оны 10 дугаар сарын эхээр Баруун хязгаарыг сэргийлэн батлах сайд Хиагтын хуралдааны тухай мэдээ авсан байна. Гэвч Оросын элчин сайдын өгсөн “Хиагтын газраа олон гүрэн элдэв хэргийг зөвлөлдөн шийтгэх хүртэл хэвээр дагаж явтугай” гэсэн заавраар Сэргийлэн батлах сайд Торгуудын бэйл, гүнгийн явдлыг шүүмжилж хүрэлцэн ирэхийг дахин шаарджээ. Улмаар Дархан гүн Балдандоржийн эрүүл мэндийн байдлыг үл харгалзан “эрхгүй хатамжин ирэхийг” ухуулсан байна<sup>19</sup>.

Аман мэдээгээр, Балдандорж ноён хорлогдон нас барсан гэдэг боловч 1915-1916 оны завсарт нас барсан тул 1914 онд түүнийг өвчтэй байсан гэсэн архивын мэдээлэлийг үнэн байж болох юм. Ховд руу албаны хэргээр очихоос шалтаглаж байсан ч Хятадын цэргээр дагуулсан Булганы Торгууд шиг Иргэн улсын харьяанд дуртайяа орох санаа түүнд байгаагүй. Жил болгон давтагдаж байсан ган зудын улмаас хошуу ихэд ядуурч таван хошуу мал нь үлэмж хорогдоод хошууны ард идэх хүнсээр ч гачигдсан учир хошуунаас Гу Чэн (古城, одоогийн *Qítái xiàn* 奇台縣)-аас хүнс худалдаж авахаар элч явуулжээ. “Гэтэл тэд нар Торгуудын нутагт хүрч тэнд байсан хятад ноёдоос зам явах бичиг олгохыг гуйсанд” тэд татгалзаж: “Танай ноёныг удаа дараачаа ирж уулзтугай хэмээсээр атал, юун учир үл ирэмүй?” хэмээн дүргүйцээд элч нарыг хошуунд нь буцааж “Одоо та нар бачим харьяат ноёныг биеэр нүүр тулан түшмэл надтай уулзахаар ирүүлсүгэй. Хэрвээ саатан хожидох буюу шалтгаалан түлхвээс танай эл бүхий тэмээ мал хэрэглэл зүйлийг бүрнээ хураан авахаар үл барам, харин ч танай хошуу нутагт ямар будлиан болохыг мэдэн чадахгүй. Одоо хоёр улсын гэрээ тогтон эв найрамдлыг хэлэлцэж буй тул харилцан нүүр уулзахад хэн этгээдэд ч цаазлан зогсоосон зүйл байхгүй” хэмээн сүрдүүлэн тушаажээ. Балдандорж ноён үүнийг сонсоод, хэдийгээр хүнд өвчтэй боловч хатуужин явах хятад ноёдтой хүрэлцэн уулзахаар морджээ. Явахаасаа өмнө Ховдод суугаа Баруун хязгаарыг сэргийлэн батлах сайдын газар руу болсон явдлыг тайлбарлаж бичиг хүргүүлсэн байна<sup>20</sup>. Уг бичигт, хятад ноёдтой уулзсаны хойно бас юу ярилцсан хэлэлцснийг даруй мэдүүлнэ хэмээн амласан. Гэвч Баруун хязгаарыг байцаан үзэж сэргийлэн батлах сайдын фондын дутуу байдлаас болоод дараагийн үйл явцын тухай тодорхой мэдээ олдсонгүй. Энэ үед Баруун хязгаарыг сэргийлэн батлах сайд Баруун хязгаарыг илбэн тохинуулах сайдтай Баруун хязгаарын хилийн тухай Их Хүрээ уруу яаралтай цахилгаан мэдээ илгээхээс өмнө Ховд дахь Орос консул Ямпиров “танай энэ мэт сул зарсан зургийн үг үсгээр авч хэлэлцэх хэрэг бус, манай Орос улсын эрдэмтний зурж үйлдсэн зургийг баримтлан хэлэлцэж зах хязгаарын байгуулах тул энэ зураг огт таарахгүй байна” хэмээн анхааруулж тайлбарлаад

хасаг хулгай нар дээрэмдэн, амь зуул үйлдэж чадахгүй болсон ба бие өвчтэй бөгөөд төлөө хүн одуулсан хэмээх зэрэг учирьг гаргаж хүмүүжүүлхийг гуйн өргөсөн хэрэг. ОӨ 4-р он 7 сарын 25 = 1914.9.14.

<sup>19</sup> А-146, д-1, ХН-1, хуудас 389г-390в, ОӨ 4-р он 9 сарын 10 = 1914.10.28.

<sup>20</sup> А-146, Д-1, ХН-1, хуудас 466г-468г. Баруун хязгаарыг сэргийлэн батлах сайдын газраас Балдандоржийн бичгийг тэр хэвээр нь Дотоод, Гадаад яам болон Ховдод суугаа Оросын консул сайдад явуулсан. ОӨ 4-р оны 9 сарын 28 = 1914.11.15.



Урианхайн Баруун гарын гүн Балдандоржийн зэрэг хошуу бүрэн бүтнээр нь Монгол улсын нутагт оруулахын төлөө хил хэрхэн тодорхойлох талаар зөвлөмж өгсөн билээ<sup>21</sup>.

Гүн Балдандоржийн бурхан болсон тодорхой он сар өдөр одоогоор мэдэгдэхгүй байна. Балдандорж ноён сэрүүн тунгалаг ахуйдаа сүүлийн удаа 1915 оны 2 дугаар сарын 10-нд бичсэн баримт байдаг. (А-128, Д-1, ХН-45, нугалбар 11: ноёдын жагсаалтад *altai-yin uriyangqai-yin sula sayid darqan jasad ulus-tur tusalayci güng baldandorji* (Баримтын огноо нь Олноо өргөгдсний 4 дүгээр оны өвлийн сүүл сарын 27). 1916 оны 4 дүгээр сарын 19-нд (ОӨ 6 дугаар оны 3 дугаар сарын 17) бичсэн баримтад нэгэнтээ Дархан гүн Балдандорж агсан хэмээн бичсэн тул Балдандорж ноён тэр үед таалал төгссөн нь батлагдаж байна<sup>22</sup>.

1916 онд гүн Балдандоржийг нас барсны хойно хошуу тамгыг түүний дүү Дархан гүний хошууны бага Хүрээний тэргүүн да лам Чүлтэм захирч Балдандоржийн бие нас барсан учрыг Дөрвөдийн баруун аймгийн чуулган дарга дайчин гүн Ядамжавын газар болон Өрөмчийн дуду 都督-ийн газар зэрэгцэн хоёр тийш мэдүүлээд засаг хошууны бэйсийн хэргэмийг Балдандоржийн ахмад хүү Жамъянжавд залгамжлуулахыг хүсчээ<sup>23</sup>.

Ховдын сайдаар дамжаад Дотоод яаманд ирсэн бичигт, Чүлтэм да лам ноёны хэргэм залгамжлуулахыг юунд Хятадын талаас хүссэн явдлыг тайлбарласан байна. Түүний айлтгаснаар түүний бие Монголын Богд эзэнд бараалхаж хишиг хүртээх дуртай боловч тэдний хошууны төв болох Алтай нурууны наран бэл буюу Чингэл голын нутаг хятад түшмэдийн баримталснаар Иргэн улсын харьяа болох тул хошуу ноён нутгаа үл алдахыг бодож өөрийн эрхгүй Иргэн улсыг дагахаас өөр аргагүй болж байна хэмээжээ. Тодруулвал, Чүлтэм да лам Хиагтын гэрээгээр түүний хошууны нутаг Иргэн улсын захиргаанд орох мэдээг Хятадын эрх баригчдаас сонсоод ихэд гайхсан гэж хэлсэн аж. Алтайн хязгаарыг зохион байгуулах бодит оролдлого нэгэнтээ 1906 оноос эхэлсэн боловч 1913-1916 оны завсарт хэрэгжиж эхэлсэн тул угаасаа харьяалагдсан Ховдын хязгаараас сална гэдэг нь Чүлтэм да лам зэрэг хошуу ноёдод итгэхүйе бэрх явдал байлаа<sup>24</sup>.

<sup>21</sup> А-146, Д-1, ХН-1, хуудас 484г-486г. ОӨ 4-р оны 7 сарын 23 = 1914.9.12.

<sup>22</sup> А-4, Д-1, ХН-414, нугалбар 5.

<sup>23</sup> Жамъянжав хэл ээрүү хүн байсан учраас ганцаараа хошуу захирч чаддаггүй, авга ах Чүлтэм да лам түүний оронд төр барьсан гэдэг.

<sup>24</sup> А-3, Д-1, ХН-775, нугалбар 3. ... Дархан гүн Балдандорж агсны тамгыг хамаарсан да лам Чүлтэм түшмэд нараас өргөсөн бичигт байцааваас үүний урьд харьяат засаг гүн Балдандоржийн бие барсан учрыг чуулганы дарга танаа мэдүүлэх цагт манай Урианхайн ардын язгуураас нутаглан суусан газар орон болвоос их төлөв Алтай уулын наран бэл болох бөгөөд товтухуй суух аргагүйн тулд гүн Балдандоржийн бие өвчнөөр өнгөрсөн учрыг Өрөмч мужийн жажин дуду-д мөн нэгэн адил мэдүүлээд түүгээр их зунтунд мэдүүлснээ их зунтунгаас Алтай Урианхай лав Иргэн улсын харьяат болох зөвтэй хэмээж гүн Балдандоржийн хөвүүн Жамъянжавыг засаг хошууны бэйсийн хэргэм залгамжлуулжээ. Одоо чуулганы даргын газраас тушаасан хэргийн ёсоор тайж Жамъянжавыг түшмэлийн хамт бараалхан очуулж богд эзэний өндөр зузаан хишгийг хүртээхүйг хүлээлгэхэд дурлахгүй хэмээх газар огт үгүй даруй дуртай сүсэглэн хүсмүй. Гагцхүү Иргэн улсын жанжин сайдуудаас хөдөлмөгч Алтай уулын наран бэлийг ямагт баримт болгож эрхгүй манай хошууны иргэн улсын харьяат болхоор гэрээ тогтсон

6 д  
газа  
Ури  
улс  
191  
дага  
оно  
зүү  
Энэ  
хош  
нэл  
ойл  
Хов  
ший  
Гом  
хош  
туш  
гар  
хош  
бар  
язгу  
тул  
бол  
хаг  
бай  
сум  
этгэ  
түр  
төс  
дур  
хош  
Мо  
идэ  
х  
с  
ч  
х  
25  
26  
а  
7

Да лам Чүлтэм бусад түшмэдийн хамтаар 1916 оны 9 дүгээр сарын 3-нд (ОӨ 6 дугаар оны 8 дугаар сарын 6-нд) Шар сүмд суугаа Алтай шаны дарга сайдын газарт бараалхан очиж Иргэн улсад дагаар орохоо илэрхийлэв.<sup>25</sup> Энэ бол Алтайн Урианхайн долоон хошууны язгуурын ноёдоос Хиагтын гэрээний дараа Иргэн улсад дагаар орохоо илэрхийлсэн анх удаагийн үйл явдал болно. (Үүнээс өмнө 1914 онд Итгэмжит гүн Галсанжав, Эрхшуну нар Алтай давж Иргэн улсад дагаар орох саналаа илэрхийлсэн. Гэвч тус хошуу бодит байдлаар нэгэнтээ 1912 оноос Алтайн нуруугаар хоёр хэсэг болж хуваагдсан бөгөөд 1914 оноос Алтайн зүүн бэлд байсан хошууны хагасыг гүн Эрхшунугийн ах Нацагдорж захирчээ.) Энэ шийдвэрийн цаадах учир шалтгааныг олохуйяа бэрх боловч магадгүй тус хошууны төв байсан Чингэл голын сав газар Шинжааны талд ороод тэр хүртэл нэлээд нягтралтай хошуу хуваагдах аюул тулгарсан гэдгийг хошууны ноёд нь ойлгосон болохоор Хятадын талын ухуулганд ороод угаасаа харьяалагдаж байсан Ховдын амбаны албан ёсны залгамжлагч Шар сүмийн амбанд дагаар орохоор шийдсэн бололтой<sup>26</sup>.

Чүлтэм да ламыг Шар сүмээс буцаж ирэх замд Саруул гүний хошууны гүн Гомбожав түүнтэй нүүр тулж уулзаад:

“Алтай Ховдын хязгаар дахь Торгууд, Хошууд, Захчин, Урианхайн зэрэг хошууд гэрээний ёсоор Иргэн улсын харьяат болох” тухай Алтайн шаны даргын тушаалыг сонсоод нутгийнхаа төлөөнөө зовнисон сэтгэлээр Дөрвөдийн баруун гарын хамаарсан чулганы даргад бичгээр хандаж “манай Урианхайн долоон хошууны дотор харьяат Дархан гүн болвоос урьд Чин улсын цагт Урианхайн баруун гарын гурван хошууны хэргийг захирах бүгдийн дарга мөний дээр манай язгуураас нутагласан газар орон цөм Иргэн улсын Алтай шаны газар мөн болох тул, нэгэн этгээд Дархан гүний хошуун газар орныг дагаж Иргэн улсад дагалдах болвоос манай өчүүхэн хошуу ангижран салж язгуурын шим өнөтэй газар орноос хагацаж аргагүйн тулд (зохиогчийн тэмдэглэл: Дархан хошууны төв Чингэл голд байхад Саруул гүний хошууны төвлөрөн суусан газар бол одоогийн Дэлүүн, Толбо сумын нутаг)... гуйх нь ... манай нэгэн хошуун язгуурын тогтсон гэрээд аль этгээдэд багтаасан, уул нутаглан суусан газар орон хэний болох, хэн этгээдэд түр албыг залгамжлан шударгыг гүйцэтгэвээс зохих аль нэгнийг эрс тасархай төсөвлөн тушаасан цагт аль эзний хишиг боловч үтээрч хоёрдан санах газаргүй дуртай хүсэн санаж журамлан явсугай” хэмээн мэдүүлснээс үзвэл, харьяат хошууны ноёд хүртэл Хиагтын гэрээний үр дагаварыг илт мэдэхгүй байж тусгаар Монголын төрд дуртайяа дагаар орсон ч түгшүүртэй цагийн үед юуны өмнө идээшиж дассан язгуурт нутгаа л хамгаалж чадвал ноёд дээдсийн заавраар хэний

хэмээхэд нэгмөсөн итгэсэн газаргүй боловч улмайран гайхаж эргэлзэх зүй үлэмжийн тулд олвоос чуулганы дарга дайчин гүн танаа өргөн мэдүүлж гуйх нь манай нэгэн хошууны ард чухам аль улсад харьяат болон алба дагнахаар тогтсон учирь уг гэрээний ёсоор заасан цагт хичээнгүйлэн дагасугай хэмээн өргөжээ ....

<sup>25</sup> А-4, Д-1, ХН-414, нугалбар 6. А-3, Д-1, ХН-775, нугалбар 6.

<sup>26</sup> Чүлтэм да лам Саруул гүн Гомбожавтай уулзаж Иргэн улсад дагаар орохоо илэрхийлсний учрыг мэдүүлэхдээ “Бид нар улс төрийн хэргийг дагаж нэгэнтээгүүр газар орныг сахихыг эргэлзэн Алтай шаны дарга сайд танаа бараалхсан” гэсэн. А-4, Д-1, ХН-414, нугалбар 6.

Талд ч ороход бэлэн гэсэн санаагаа илэрхийлсэн байна<sup>27</sup>.

1915 оны өвөл, 1916 оны хавар Алтай шан уулын яамнаас Урианхайн хошуудад олон зүйлийн ухуулга, дүрэм, тушаалын бичгүүд ирж эхэлсэн бөгөөд харьяат ноён эл бичгүүдийг Хятадын талаас “эзэрхэн хүчимдэж” байгаагийн шинж хэмээн үзэж, үүний тухай удаа дараа Ховдын сайдад гомдлоо мэдүүлж байв. Дархан хошуунаас бусад Алтайн Урианхайн хошуунууд “элдэвт Иргэн улсын түшмэлд эзэрхийлэхгүй” болгохыг шаарджээ.<sup>28</sup> Гэвч Да лам Чүлтэм Дундад улсын бодлогыг 1923 онд Монгол улсад дагаар орох хүртэлээ тасралгүй баримталж байв.

**Балдандорж ноёны аман уламжлалын дүр ба түүний гэр бүл:** Аман уламжлалын дагуу Балдандорж амбан бол тус хошууны удам дамжин төр барьсан ноёдын нэг болох бөгөөд Ах сумны Бага Холдон элхний хүн болно.

Ноёны удмын хүн болох Чингэлийн Батцагаан багшийн хадгалсан аман уламжлалын мэдээгээр Балдандорж ноён тус хошуу ноёдын 13 дугаар үеийн ноён ажээ. Тэгсэн ч Бага Холдон элхний эхний үеийн удам судар бүдэг бадаг байна. Чингэлийн Зандваа туслагчийн үр садан Мажиг, Батцагааны тоочин өгүүлсэн Илдэн Хар амбан, Цэрэн тайж, Наран хар амбан гэсэн гурван нэрээс гадна, Булган сумын аман уламжлалаас зөвхөн Хилэн хар буюу Дэлэг ноёны нэр мэдэгдэж байна. Эдний хоорондын харилцаа, дэс дараалал тодорхойгүй үл барам ихэнх нэр нь жинхэнэ нэр биш ард түмний авгайлж хүндэтгэсэн хоч нэр болох нь тодорхой мэт.

Балдандоржийн өвөг аав Сайнбилэг амбан гэгч хүн бол тус хошууны ноёдын угсаанаас 1891 оны архивын баримтад тэмдэглэгдсэн анхны ноён болно<sup>29</sup>. Түүний хөвүүн Балдандоржийн аав Самбуу тайж аман мэдээгээр, нутаг захирах чадваргүй тааруухан мөртлөө бөх хүн байсан бөгөөд хийд хүрээнд домботой сүү хүргэж явахад тэмээтэй согтуу явж байгаад казах хүнд алагдажээ. Тэгээд алсан хүн түүний хүүрийг Өрөнгийг гол руу шидчихээд чулуугаар дарчихсан гэнэ<sup>30</sup>. Сайнбилэг Самбуу хоёрыг нас барахад Самбуу тайжийн хөвүүд болох Дамбадорж, Балдандорж, Чүлтэм, Зандаваа насанд хүрээгүй болохоор лам хүнийг харлуулж, Их Холдон элхний Дашцэвэг гэдэг хүнийг ноёноор тавьсан байж гэнэ. Дашцэвэгийг хошууны зарим албат нар “уггүй ноён” хэмээн эсэргүүцэж, Шолог Шонхор гэдэг хүн ноёнттойгоо хэрэлдснээс болоод хошуунаасаа түр оргож явсан түүх бас бий<sup>31</sup>. Жоожа амбан буюу Өвгөн ноён хэмээн “аакалж” (хүндэтгэж) нэрлэсэн Дашцэвэг олон жил нутгаа захираад нас

<sup>27</sup> А-4, Д-1, ХН-414, нугалбар 6.

<sup>28</sup> А-3, Д-1, ХН-775, нугалбар 8. ОО 6 оны 4 сарын 29 (= 1916.5.3.) өдрийн Гадаад яамны бичиг.

<sup>29</sup> М-161, Д-1, ХН-1, хуудас 2v-4v болон М-163, Д-1, ХН-9 дугаартай баримтаар 1891 онд хоёр удаа тэмдэглэгджээ. Үүнээс өмнө тус хошууны ганц ноёны нэр тодорхой боловч аман уламжлалаар дамжуулсан Бага Холдон элхний ноёдын удам судартай харьцуулхын аргагүй байна, тодорхойлвоос 1812, 1823 онд нэрлэсэн Исүний хөвүүн сул амбан Молондаржаа болно М-1, Д-2, ХН-273, Qobdu-yin jasy-un kereg-ün bügüde čese 科布多事宜 (富俊等輯), 1823 он.

<sup>30</sup> Ховд аймгийн Мөнххайрхан сумын Б.Ханджавын (1926) 17.7.2013-нд хэлснээс тэмдэглэв.

<sup>31</sup> Мөн тэндээс.

нь өт  
хүүгэ  
олон  
Самб  
явахд  
газрь  
бусы  
шөне  
“хул  
Б.  
түүн  
оны  
Ч  
хүүж  
(1908  
(Б.Ха  
Шар  
Хамг  
Улаа  
хорд  
айлт  
жилт  
Балд  
бас  
хүүх  
Цэнд  
Бөөр  
улсы  
1984  
хэмэ  
Б  
Маг  
болс  
Жам  
Жам  
ламь  
Амаг  
32 Ба  
тэ  
33 М  
34 Э  
А.  
ил



нь өтөлж явтал Шар залан, Готов цорж (өөр мэдээгэр бас Мянгаа) гэдэг хоёр хүүгээр ноёны хэргэмийг залгамжлуулах санаа оролдлого тавьсан ч хошууны олон ард эс зөвшөөрч насанд хүрсэн Балдандоржийг ноён болгов. Завсарт нь Самбуугийн ахмад хөвүүн Дамбадорж Жоожа амбаныхантай төр булаалдаж явахдаа Жоожа амбаныхан түүнийг Цагаан голд буруу гатлага (гатлагагүй газрыг) зааж өгөөд усанд үхүүлчихсэн гэнэ<sup>32</sup>. Магадгүй Жоожа амбан ч гэсэн ер бусын жамаар бурхан болсныг өгүүлвээс түүнийг хөгширөөд “зүүлдэг” болоод шөнө гараад тойрж байгаад гэр орноосоо холдоод адуу манаж байсан казах хүн “хулгайч ирлээ” хэмээн түүнийг андуурч алсан гэдэг<sup>33</sup>.

Балдандорж амбаны төрсөн он тодорхой биш боловч нас барсан 1915 онд түүний нас 33 буюу 37 хүрсэн гэдгийг үзвэл, 1883-1884 оны үед эсвэл 1879-1880 оны хооронд төрсөн бололтой.

Чингэлийн Батцагаан багшийн мэдээгээр, Балдандорж ноён нийт 12 хүүхэдтэй байсан ч 7 хүүхдийн нэр мэдэгдэж байна. Ахмад хүү Жамъянжав (1908 мичин жил – 1969) эцгийнхээ дараа ноёны цол залгамжилж авсан байна (Б.Ханджавын мэдээгээр хий насаар 9 настайд нь). Түүний хоёр дахь хүү Шар гэцэл ноёны ширээ булаалдаад ганцаараа Монгол улс руу нүүсэн гэдэг. Хамгийн их сонирхол татмаар хүү бол Их Улаан лам буюу гурван удаа тодорсон Улаан гэгээн хэмээгдэх хүн болно. Энэ гэгээн 25 насандаа хар хулсны хороор хорлосон архи уугаад нас барсан бөгөөд төрөл егүүтгэх насаа урьдчилан мэдэж айлтгасан гэнэ. Балдандоржийн отгон хөвүүн Довдон гэдэг байж (1915 туулай жилтай). Балдандорж бас Чойрон (Чойрог), Нимжаа гэдэг хоёр охинтой байжээ. Балдандоржийн нас барсны дараа түүний хатан Амаржаргал Чүлтэм да ламтай бас хоёр хүүхэд төрүүлсэн нь цаг хугацааны хувьд тодорхой мэт боловч тус хүүхдүүд Балдандорж амбаны хүүхдүүдийн тоонд тооцогдодог байв. Нэг нь Цэндээ (1918 морин жил – 1968) гэдэг охин Балдандоржийн эмэгтэй дүү байсан Бөөр, түүний нөхөр Зул хоёрын өөрийн хүүхэдгүй айлд өргөгдсөн тул Монгол улсын нутагт (Булганд) үлдсэн. Дараагийн нэг нь Сэнгэ (1920 мичин жил – 1984.4.3.) Чингэлийн талд үлдэж лам болоод ардын дунд Бага улаан гэгээн хэмээн алдаршсан.

Балдандорж ганц хатантай, түүний нэрийг Амаржаргал гэх бөгөөд Торгуудын Магнай захирагчийн охин гэдэг. Тэр 16 насандаа Балдандорж ноёны хатан болсон гэдэг. Балдандорж амбаныг бурхан болсны дараа түүний ахмад хөвүүн Жамъянжав бас эцгийнхээ загвар жишээгээр Торгуудаас хатан залсан түүхтэй. Жамъянжав ноёны хатан Урианхай Торгуудын маргаанаас болоод Тангад ламын хараалын уршиг нөлөөгөөр хадмынхаа гэрт оронгуут нас барсан гэдэг<sup>34</sup>. Амаржаргал хатан түүнтэй нутаг гарал нэгтэй тул түүний үхэлд бусдаас илүү

<sup>32</sup> Баян-Өлгий аймгийн Булган сумын Р.Чадраабалын (1945) өгүүлснээс 2015 оны 5 сарт тэмдэглэж авав.

<sup>33</sup> Мөн тэндээс.

<sup>34</sup> Энэ түүх бол Алтай Урианхайн Баруун амбаны хошуу, Булганы Торгууд, Захчин, Шинжааны Алтайн Хандгайт, Хошууд шиян хүртэл өргөн дэлгэрсэн олон хувилбартай түүх болхоор тусгай илтгэлээр өгүүлнэ гэж бэлтгэж байна.

харамсаж байсан гэнэ.

Амаржаргал хатны нэр нэгд Мажиг Батчулууны өгүүлсэн хошуу ноёны ургийн удам судрын уламжлалаас, хоёрт Мөнххайрхан сумын Ханджав гуайн өгүүлсэн мэдээнээс илэрсэн болно. Харин архивын баримтад Балдандорж ноёны хатны нэрийг ганц удаа дурдагдсан бөгөөд түүнийг Өлзийдэлгэр гэсэн нэртэй хэмээн бичсэн байна<sup>35</sup>. Балдандорж амбаныг хоёр хатантай байсан тухайд нутгийн настангууд яриа болон бусад аман сурвалжийн мэдээ одоогоор байхгүй байна. Харин хатны нэрийг хоёр янзаар бичсэн бололтой.

Ханджав гуайн ярьснаар, хошууны албат ноён дээдсийнхээ нэр алдрыг ямагт хүндэтгээд асууж дуудахыг ихэд цээрлэдэг байсан төдийгүй цаашилбал огт мэддэггүй байсан ч учраас Амаржаргал хатны нэр цухас төдий түүхэнд үлдсэн байна. Нутаг олноор хатныг Бичкэн аак (Бяцхан ээж) гэж нэрлэдэг байжээ. Нэг удаа Амаржаргал хатны дагуул хүүхэн (үйлчлэгч зарц) хийж байсан Улаан аак гэж хочилсон Тошил гэдэг бүсгүй бас нэг хэдэн зарц нарын хамтаар Урианхайн ноёноос хадам аав, ээж нь болох Магнай захирагчид хурс (хурууд), гүзээтэй тосон хүргэхээр явсан билээ. Тэгээд ноёны өгүүлсэн бэлгийг хүлээлгэн өгөхөд нь Магнай захирагч охиныхоо мэндийг асуувал: “Манай Амаржаргал хатан, эгтэй тайжтайгаан сайн суурилж байна уу?” (Хөвүүдтэйгээ сайхан сууж байна уу гэсэн утгатай ноён хүнд хандаж хэлдэг хүндэтгэлийн үг.), гэсэн тул хүмүүс “Бичкэн аакын нэр тийм байж биш уу” гэж хэлэлцдэг болсноос хатны жинхэнэ нэрийг мэдэж авсан гэдэг<sup>36</sup>.

Амаржаргал хатан 1932, 1933 оны орчимд таалал төгссөн бололтой. Учир нь: Бага хүрээ Чингэлийн талаас буцаад Цэнхэрт давж ирсэн үед “Бичкэн аак нас барчихжээ гэнэ, манай бага Хүрээнд мөр гаргах гэнэ” гэсэн сураг гарч байсныг Б. Ханджав (1926 онд төрсөн) санаж дурсан ярьсан юм<sup>37</sup>.

**Жа лам Дамбийжанцантай Балдандорж маргалдаж ялсан нь:** Нутгийн хүмүүсийн аман яриагаар Балдандорж амбан “царайлаг, нуруу тэгш”<sup>38</sup> их ухаантай, “зүгээр ч биш, сүрхий хүн”<sup>39</sup> байсан гэдэг. Түүний авьяас чадвар тодорсон гол учир бол тэр үед *Баруун хязгаарын олон монголчуудыг дагуулан тохинуулах цэргийг захирах сайд ноён хутагт Номун хан* болж явсан Жа лам Дамбийжанцанд түүний аймшиггүй хандлага болно.

Архивын баримтаар сайн тэмдэглэгдээгүй энэхүү нэгэн учир аман уламжлалаар дамжин ирсэн байна. Аман түүхийн судлагааны хүрээнд түний хоёр хувилбарыг тэмдэглэж чадсан.

<sup>35</sup> Алтай Урианхайн долоон хошууны ноёдод олгож байсан цалин пүнлүүгийн цэсийн ноорог, ойролцоогоор 1914 он (А-130, Д-1, ХН-38): *altai-yin uriyangqai-yin sula sayid darqan jasay ulustur tusalayci güng Baldandorji-du mönggü 52 lang. tory-a 6. / egünü gergei Öljeidelger-tü tory-a 2. / temdeglegsen aqamad köbegün yudayar jerge tayiji Jamiyangjab-tu tory-a 1.*

<sup>36</sup> Ховд аймгийн Мөнххайрхан сумын Б.Ханджав (1926)-ын 2014.6.13-нд Баянсайд байгаа зусланд нь хийсэн дууны бичлэгийн 5-дугаар хэсгийн 24:25-28:00 минутад. Зохиогчийн хувийн архив.

<sup>37</sup> Ховд аймгийн Мөнххайрхан сумын Б.Ханджавын Баянсайд 2013.7.17.-нд өгүүлсэн мэдээ.

<sup>38</sup> Пунцагдорж – Сайнбилэг 1999

<sup>39</sup> Б.Ханджав.

Т  
мэдэ  
Архи  
хошу  
өргө  
олдо  
М  
нь ан  
дэмж  
хэлл  
маяг  
явда  
Ийм  
Дамб  
хэрх  
Л  
хүни  
күмү  
дууд  
ядаа  
Цоо

байа  
Жаа  
байс  
тэтг  
“Дө  
хэнт  
үгээ  
“Дө  
хүч  
(хөл  
дур  
Бал  
дог



Тус хошууны аман түүхэнд Дамбийжанцангийн цэрэгт явсан хүний тухай мэдээ байгаа боловч бусад хошуунаас харьцангуй цөөхөн хүн явсан бололтой. Архивын хөмрөгт хадгалагдаж буй “Дамбийжанцангийн хувийн ба шавь хошууны тухай цуглуулга”-д (А-135) Алтай Урианхайн бүх хошуунаас шавьд өргөсөн хүмүүсийн жагсаалт байгаа боловч Дархан гүний хошууны ийм бүртгэл олохгүй байна.

Мөнххайрхан сумын өндөр настан Банзарын Ханджавын өгүүлсэн аман түүх нь аман мэдээний олон шинжийг хадгалж байгаа. Амаар уламжилж цээжлэхийг дэмждэг нэгэн арга барил бол толгой холбож шүлэглэсэн хагас тогтсон хэллэгээс бүтсэн хүүрнэл юм. Өгүүлэмжийн хоёрдугаар хэсэгт, хошин шог маягийн харилцах яриа гарч байна. Энэхүү түүхийн дамжуулганд бодит түүхийн явдал хойшоо ороод наад талд хүний зан чанар, сэтгэл санаа илрэн гардаг. Иймээс тус өгүүлэмжээр дамжаад тухайн үеийн Алтайн Урианхайчууд Жа лам Дамбийжанцан, гүн Балдандоржийг хэрхэн үнэлж, эдний зан төрх, ааш явдал хэрхэн дүгнэж байсан тухайд шууд мэдэж авах боломжтой юм. Тухайлбал,

*Жаа лам гэдэг нэг юм алдаг күмүн ирсэн, Дамбийжаа. [Ямарваа нэгэн хүнийг] авчираад дан цокаад алаад байдаг, алаад байдаг, тэр Жаа лам гэдэг күмүн. Тэр Дөрвөдийн күүрээ гэдэг нам бараг алсан. Жаа лам Балдандоржийг дуудуулаад байдаг, дуудуулаад байдаг ирдэггүй. [Балдандорж сүүлд нь тэсэж ядаад] цоохор морь унаад, цоохор морь содон [шодон] сүүлтэй байсан юм. Цоохор морь унаад Жаа ламд ораад гарсан, [Жаа лам Балдандоржид:]*

*“Таныг хар китадаар бөгсөө нөхсөн,*

*хар хасгаараа хаяа кийсэн,*

*дөрвөн ац кэлтэй,*

*дөрөө зузаан арстай,*

*дөрүүхэн [= дориухан] залуу байдийм болгосон. Хар Махгал мөн биеэрээ байж биш.” Хар Махгал гэж бурхан [байдаг].*

Тайлбар: “*хар китадаар бөгсөө нөхсөн, хар хасгаараа хаяа кийсэн*” гэдэг нь Жаа лам Дамбийжанцан Балдандорж амбаныг Дамбийжанцагийн ад үзэж өшилж байсан аливаа дайсантай ханилан нөхөрлөж, эд нараар өрийнхөө байр суурыг тэтгэж яваа гэж буруугаар ойлгоод шүүмжилж байгаагийн илэрхийлэл болно. “*Дөрвөн ац кэлтэй*” гэвэл ац нь салаа гэсэн утгатай, хэл сэтгэлгээрээ бусад хэнтэй ч амархан хэл ололцдог, дайсантай ч амархан нийлдэг, хурц уран үгтэй, үгээрээ хүнийг амархан даван чадаж байдаг хазгай ойлголтоо илэрхийлсэн. “*Дөрөө зузаан арстай*” гэхээр түүнийг хөрслөг бор залуу, жавхаатай эрүүл хүчтэй баатар гэж хэлсэн бололтой. *Дөрвөн ац кэлтэй* гэдгийг *дөрвөн ац кэлтэй (хөлтэй)* гэж ойлгож бас болно. Ийм бол өөрийн хоёр хөлөөс бас өмнөх үгэнд дурдсан Казах, Хятад хүнийг түшдэг гэсэн утга байж магадгүй. Дамбийжанцан Балдандоржийг шүүмжилж буруушаан үзэх үг түүнийг Хар Махгал бурхан шиг догшин аюултайг үлгэрлэснээр төгсөж байна.

*[Балдандорж хариуд нь:] “Тэгэхээр амьтан намайг ойртсондаан өлзийгүй, харгалдсандаа хаяагүй гэдэг билээ. Багш намайг сайн гэж хэлэв.”*

Тайлбар: Балдандорж ноён Дамбийжанцангийн үгэнд ёгт аргаар хариу өгч

байна. “Надад хүмүүс дургүй байдаг. Надтай уулзсан хүнд би ивээлгүй (бас “харгалдсандаа хавиргагүй” гэж ярьдаг), тусламж гуйсан хүнд эвтэй санаагүй, хүн бүхэнд найрамдалгүй хатуу хэрцгий зантай хүн болно. Жаа лам багш та миний зан авирыг зөв онож хэлсэн” гэж маш уран хэтрүүлэлтэй үгээр өгүүлэв.

*Одоо Баяндэлэг гэдэг хүмүүн<sup>40</sup> эс билүү тэр Жаа ламаан цэрэгт байлуу. Манай Урианхайгаас их цэрэг татаж байсан. Тэгээд ардий [ард нь] долоо хоноод гэдгийг билүү, цагаан орос барьж аваад явж одлаа. Манай Балдандорж амбан үнэн кэлсэн болниш, цаг нь болсон гэж кэлж байж.*

*Тэгээд одхаар манай Балдандорж амбан цоохор морьтой явж байсан болж байна.*

*“Та цоохор морьтой байна ууч?” гэж Жаа лам Дамбийжанцан асуусан.*

*“Тийм ээ, яана?”*

*“Одон цоохор морьтой хүмүүн над*

*Ор явган шиг харагдана.”*

*Тэгээд Балдандорж амбан:*

*“Та орос хувцастай юм аа?”*

*“Тийм ээ, яана?”*

*“Орос хувцастай хүмүүн над*

*Ор нүцгэн шиг харагдана”<sup>41</sup>.*

Тус өгүүлэмжийн хоёрдугаар хувилбарыг Баян-Өлгий аймгийн Булган сумын Цөнхөл багийн алдартай анчин агсан Содномын Балдаа өгүүлэв:

*[Жаа лам] манай [Балдандорж] ноёнаас их айдаг. ... дахиад ардий цэргийн агт, тавин морь өгчих [гэж Урианхайн нэг ноёнд тушаасан, даруй хэлснээр Саруул гүн байсан]. Тавин морийг авчираад хэдэн цэрэгт өгөөд нэг морин тоглаад нэг цэргийг бэртээчихэв. Тэгээд тэр нояаг авчираад эрүүдээд эхэлж, тун одоо болва. Тэр ноёнаакан манай ноёнд чимээ өгчээ: “манай нояагий эрүүдэж байна.” Тэгээд манай ноён одаад, [Жаа лам] харуул манаатай, манаа “зогс, зогс,” манай ноён ганцхан довтлож орно. Жаа ламын үүдэн дээр нь: „Жаа лам, гараад ир гараад ир!” – „Ноём, ноём, хөлгөөн тавчихаад буутан, буутан,” гээд ийгээд, „Чи юу юмч? Эх болсон зургаан зүйлийн амьтанд тус болдог лам хүмч уу, шулам хүмүүнч уу? Юу гэж хүмийг эрүүдэж байнач?” Яриад яриад буулгаад гэрт орлоод цай уугаад. Манай ноён цэрэг өгдөг ч гүй. Манай ноёноос их айдаг. Тэгээд манай ноён очноос [хойно] Хатанбаатар Магсаржав дарж байдаг нь тэр<sup>42</sup>.*

<sup>40</sup> Баяндэлэг гэдэг хүн бол Мөнххайрхан сумын нутагт их нэр хүндтэй гэр бүлгүй ядуу өндөр ууланд ганцаараа амьдардаг хар багш домч. Нутгийн хүмүүс түүнийг Алтай уулын эзэн савдагтай харьцаж чаддаг, аливаа хэрэгцээнд хүнд тусалдаг хүн гэж магтан өгүүлдэг. Баяндэлэг бол Жаа ламын цэрэгт орсон тус хошууны цөөн хүний нэг байсан. Түний тухай өгүүлэл: Srba 2011.

<sup>41</sup> Ховд аймгийн Мөнххайрхан сумын Баянсайд зусдаг Банзарын Ханджав (1926)-ын 2013.7.18.-нд ярилцсан дуун бичлэгийн нэгдүгээр хэсгийн 01:01:10-01:04:00 минутад. Зохиогчийн хувийн архив.

<sup>42</sup> Баян-Өлгий аймгийн Булган сумын Содномын Балдаа Түргэн голд байсан өвөлжөөндөө 2015.5.12-нд хийсэн дуун бичлэгийн 2 дугаар хэсгийн 24.38-26.10 минутад. Зохиогчийн хувийн

**Балдандоржийн нас барсны тухай:** Балдандоржийн бурхан болсны тухай хоёр зүйлийн яриа байдаг. Алтай Урианхайчууд дээр үеэс өнөө хүртэл сур харвах заншилаа идэвхтэй хадгалан хөгжүүлж ирсэн түүхтэй.

Одоогийн Булган сумын Урианхайчууд юуны өмнө өвөл цаг цагаан сарын үед мөсөн харваа хэмээн голын мөсөн дээр сур харвадаг юм. Балдандорж ноён өвлийн цагт сур харваж байхдаа нас барсан гэнэ. Зарим хүний хэлснээр, цус харваад гэнэт нас барсан<sup>43</sup> гэтэл олон хүний хэлснээр зориуд хорлогдсон гэдэг.

Хятад хүмүүс (өөр хэллэгээр Жоожа амбаны талынхан<sup>44</sup>) түүний морины дөрөөнд хор түрхээд хор нь гутлын улд халдаад гутлын улаар дамжаад хөл давираад хорлогдсон<sup>45</sup> гэдэг. Энэ явдал Булган голын Туулайтын аманд<sup>46</sup>, Булганы Улаан хусны Их Төмөртийн салаанд буюу түүний аманд<sup>47</sup> эсвэл Дэлүүн сумын Бүргэдийн аманд<sup>48</sup> болсон гэж олон янзаар хэлдэг. Балдандорж ноёны шарилыг оршуулсан газар нь тодорхой бөгөөд Их Төмөртийн Хундагатын Шарилын салаанд чулуу модоор хийсэн бунхан нь одоо хүртэл харагдаж байна гэдэг<sup>49</sup>.

Мөнххайрхан сумын Б.Ханджав гуайн өгүүлснээр, Балдандорж 33 насандаа нас барсан гэнэ. Тэгэхэд нас барахад нь лам зурхайчид Алтан хайрцаг гэдэг судраар “шинжээ сөхөөд” түүнийг “Хурмастын зүүдээр ирсэн хүн” байсан гэдгийг мэдсэн гэдэг.

Учир нь: Хаан Хурмаст нэг унтхаар 33 жил унтаад дунд замбутивд ирээд ноёны хөвүүн болж, ноён болоод, хатан аваад, сэрж босохоор хүн нь өнгөрч оддог яриа байдаг гэсэн<sup>50</sup>. Балдандоржийн тухай ийм үг тархсан байдгийг бас Булган сумын Р.Чадраабал батлаж байна.

### Дүгнэлт

Манжийн үед Алтай Урианхайн Баруун гарын гурван хошууны сул амбан, Олноо өргөгдсөн Богд хаант Засгийн үед Дархан гүн Балдандорж, нутгийн хэллэгээр Балдандорж амбан хэмээх ноён нь хошуу нутгаа захирсан цаг хугацаагаараа түүний залгамжлагч Чүлтэм да ламыг бодвол, Алтай Урианхайн түүх судлалд бүдэг байгаа боловч нутгийнхаа түүхийн аман уламжлалд их эрхэм

архив.

<sup>43</sup> Булган сумын Р.Чадраабалын ярианаас 2015 оны 5 сарг тэмдэглэж авав. Бас Пунцагдорж – Сайнбилэг 1999: 16 түүнийг “өвөл сур харваж байгаад удалгүй таалал төгссөн гэнэ” гэж бичсэн.

<sup>44</sup> *Алтайн Урианхайн угсаатны зүй* 2014: 27. Энэ хэрэг цагаан сарын шинийн гурванд болсон гэнэ.

<sup>45</sup> Балдандорж/Чүлтэм да ламын охин Цэндээгийн хүү Цогтбаярын Шархүү (1936) Булган сумын Хөх толгой гэдэг газарт байгаа өвөлжөндөө 2012.5.15., 2014.5.14. хоёр удаа хэлсэн аман мэдээ.

<sup>46</sup> *Алтайн Урианхайн угсаатны зүй* 2014: 28.

<sup>47</sup> Цогтбаярын Шархүүгийн 2014.5.14-нд өгүүлснээр.

<sup>48</sup> Чингэл шияны Какааны Бэкээн/Батцагааны 2013.1.20-нд өгүүлснээр.

<sup>49</sup> Пунцагдорж – Сайнбилэг 1999: 16 бичснээр Балдандорж амбан тэр үед Их төмөртийн Хундагатын доод аманд хатгамал хашаа гэдэг газарт өвөлжиж байсан гэнэ.

<sup>50</sup> Ховд аймгийн Мөнххайрхан сумын Б.Ханджав (1926)-ын 2014.6.13-нд *Баянсайд байгаа зусланд* нь хийсэн дууны бичлэгийн 5-дугаар хэсгийн 29:30-31:00 минутад. Зохиогчийн хувийн архив.



байр суурь эзэлж байна. Түүхийн аман уламжлал Балдандорж ноёныг өндөр чадалтай, өөртөө тустай, өөртөө итгэлтэй, аль ч талын нөлөөнд орохгүй сүрхий баатарлаг хүн гэж үнэлжээ. Залуу насанд (Б.Ханджавын өгүүлснээр 15 наснаасаа ноёны хэргэм хашсан) ноёны уг язгуургүй сонгож томилогдсон бүгдийн дарга Дашцэвэгийн үр хүүхдүүдтэй ах дүүгийнхээ хамт ноёны тушаал булаалдаж, Ховдын манж амбантай заргалдаж явсан түүхтэй гэнэ. Тус хошууны ноёны удам судар, үе залгамж Манжийн үе, Автономитын үеийн Илтгэл шастирт ороогүй ч гэсэн, тус хошууны аман уламжлалд өгүүлснээр, хошуу ноёны хэргэмийг ямагт нэг овгийн хүмүүс үеэс үед дамжуулдаг байсанд нутгийн хүмүүс гүн итгэгдсэн байна.

Юутай ч Балдандорж ноён Бага Холдон элжний байр сууринд их чухал нөлөө үзүүлсэн юм. Түүнийг Хурмастын зүүд, цаашилвал Хурмастын хувилгаан хэмээн үзсэн нь түүний биеийг домгийн шинжтэй болгосон байна. Түүний тухай ярьж байгаа аливаа аман түүхийн өгүүлэмжид түүхийн бодит үйл явдлыг тодорхойлохоос илүүтэй түүний ач холбогдол, нутаг хошуундаа бүтээсэн үйл хэрэг нь чухал юм.

Дархан гүний хошуу бол Урианхайн баатарлаг туульсийн голомт гэдгийг санаваас Балдандорж ноёныг нутгийн түүхийн аман уламжлалт туулийн баатрын дүрээр дүрслэлсэн явдал ойлгомжтой байна.

**DARHAN GÜN BALDANDORJ, GOVERNOR  
OF THE RIGHT BANNER OF ALTAI URIANHAI:  
ARCHIVE DOCUMENTS AND ORAL TRADITION**

**Ondrej Srba, Masaryk University in Brno – Charles University in Prague  
(Czech republic)**

The Right Banner of Altai Urianhais is one of the former Seven banners of Altai Urianhais and is significant by its uninterrupted continuity of its population living in the area up to the present days (Mönhhairhan, Duut sums in Hovd aimag, Bulgan sum in Bayan-Ölgii aimag and Činggel siyan in the Altai Municipality of Xinjiang Uyghur Autonomous Region, PRC). This continuity enabled a development of a particularly ample historical oral tradition, in which the oral memory of local nobles and banner governors plays the most important role. Due to the total loss of banner archives is the oral tradition attended to compensate for the nonexistent written sources. The article brings together the archive documents mentioning Darhan gün Baldandorj (Darqan güng Baldandorji), one of the most colourful personages of the local oral tradition. The archive materials emphasize his voluntary submission to the new Mongolian government in Ih hürée (Yeke küriy-e) in 1912 and his role in defending his banner against Kazakh incursions. In October 1913, Xinjiang Torgud Palta wang concluded a treaty with Russian consul Kuzminskiy which divided the territory of Altai Urianhais by the peaks of Altai range, the status subsequently confirmed by the Kyakhta Treaty of 1915. Urianhais nobles being rather uninformed about the international situation sought to preserve unity of their territory. Archive documents imply that Baldandorj tried to overcome the pressure by the Chinese officials and keep his subordination to the Mongolian authorities in Hovd. However after his untimely death presumably at the beginning of 1916, his successor and brother Chultem Da lam (Čültüm da lama, ruling instead of his nephew Jamiyanjav/Jamiyangjab) came to a conclusion that only a submission to the representatives of the Chinese Republic in Altai (Shar süm/Sir-a süm-e) would allow to keep at the hands of Urianhais the central and the most fertile part of the banner's territory laying on the southern slopes of Altai range in the basin of Činggel river.

Whilst the scarce archive sources does not allow to asses Baldandorji's real decisions and thoughts, which are obscured by the diplomatic language of official documents, the oral tradition gives out detailed facts of Baldandorji's life and emphasises his meritorious acts for his banner. It describes Baldandorj as a hero of supernatural qualities and underlines his unearthly character by identifying him with the supreme deity of Hurmast Tenger (Qurmusta tngri), which is a frequent method of the Mongolian popular oral tradition. In general, the case of Baldandorj proves the importance of oral tradition for the understanding of the Mongolian local histories.



ХОЛБОГДОХ БАРИМТУУД

№1

**АЛТАЙ УРИАНХАЙН БАРУУН ГАРЫН СУЛ АМБАН БАЛДАНДОРЖ  
МОНГОЛЫН ТУЛГАР ТӨРД ДАГААР ОРОХ ХҮСЭЛТЭЭ  
ИЛЭРХИЙЛСЭН БИЧИГ<sup>51</sup>**

Батлан өргөх бичиг.

Алтайн Урианхайг захирагч баруун гарын бүгдийн дарга Балдандоржийн бичиг. Зарлигаар зарсан баруун хязгаарыг сэргийлэн батлах сайд цэргийг бүгд захиран шийдгэгч яамны дэд сайд зоригт бэйс, зөвлөж хавсран шийтгэх зарлигаар шагнасан түшмэл сайнтай номун хаан Жалханз хутагт танаа өргөв.

Хүсэн баталж мэдүүлэх нь. Манай Халх Монголчуудыг манж хятадын сайд түшмэлүүд дээдийг мэхлэж доордыг даралхийлан хашируулан зовоосон бөгөөд Манж Хятад нар өөсөө төр самууруулсан учир, манай Халх Монголчууд бүгдээр зөвлөлдөн тусгай улс төр тулгар байгуулан тогтоохоор нэгэнтээ тогтож Очирдар богд Жэвзундамба гэгээнийг хаан өргөмжлөн олон Монголчуудаа амруулан шашин номоо бататгахыг үүний урьд Жалханз хутагтаас ухуулан зарлан ирсэн бичгийг хүлээн авч наманчилан залбирч зөвлөлдөн гүйцэтгэхийг завсраа баруун хойд хязгаарын их Монголын эрдэнэ биширэлт засаг лам Дамбийжанцан морилон ирж элдэв учрыг сэнхрүүлэн ухуулж ачлан, унтсан мунхагын харанхуй гэнэт сэргэж бүгдийн дарга Балдандорж миний харьяат хошуу ба, хавсран захирсан дарга Гомбожав, Очиржав нарын гурван хошууны шар хар олон даяар амар жаргахыг хичээнгүйлэн хүсэж Очирдар богд хааны тулгар төрд баярлан дагаар орж шашин номыг улмаар бататгаж нийтээр цэнгэлдэн баярлаж богд эзний хүнд хишиг сургууль соёл хүртээхийг гүнээ хүсэн батлах бичгийг гаргаж олдвоос сайд зоригт бэйс, номун хан Жалханз хутагт Танаа батлан мэдүүлээд толилон үзэж уламжилан айлтгаж бид бүхийг авран энэрж гүйцэтгэн асран тэтгэмжилэх ажааму. Үүний тул батлах бичиг өргөв.

Олноо өргөгдсний хоёрдугаар он зургаан сарын хорин найм. [1912.10.8.]

№2

**ГҮН БАЛДАНДОРЖИЙН НУТАГ КАЗАХЫН ДЭЭРЭМД  
УДАА ДАРАА ХЭЛМЭГДСЭН ТУХАЙ БИЧИГ<sup>52</sup>**

Дөрвөдийн баруун гарын үнэн зоригт хан аймгийн туслагч жанжин Захчины засаг улсын туслагч гүн Самбуу.

Хамаарсан чуулганы дарга Мянгадын дайчин засаг улсад туслагч гүн Ядамжавын бичиг.

<sup>51</sup> МУУТА.ХА-141.Д-1.Хн-5.Н-8.

<sup>52</sup> МУУТА.ХА-128.Д-1.Хн-3.Х-266-267.

Зарлигаар зарсан Баруун хязгаарыг тохинуулах цэргийг дайчлан захирах сайд хатан баатар хошууны бэйс.

Их Монголын зарлигаар өргөмжилсэн Баруун хязгаарын олон монгол аймгийг дагуулан тохинуулах сайд эрдэнэ бишрэлт үнэн хүчин төгөлдөр номун хан ноён хутагт.

Зарлигаар зарсан Баруун хязгаарыг тохинуулах цэргийг захиралцах сайд чин ачит бэйл танаа өргөв.

Өргөн мэдүүлэх учир.

Өдгөө энэ он долоон сарын арван гурваны өдөр [1913.8.14.] манай нутаг Чингэл голын бэлчир хэмээх газраа байсан лам хүрээний зөөр тавьсан газарт хасгийн хоёр зуун хүн зэвсэг барин хүрч ирээд сахисан хүн нарыг буудан хөөж бурхан номыг бүрнээ эвдэн самшуулж бүхүй тавьсан эд юм ба, бурхан номын хэрэгслийг дээрэмдэн авч мөн шөнө нутгийн захад жаран буугаар буудаж хуяг Бажуунаг нарын арван илүү өрхийг дайчлан байхул хогшил хөрөнгийг дээрэмдэн авсан улмаас хошууны цөөн арад хэнээрлэн айж гэрийн хөрөнгийг орхиж хээр нуун далдлаж байтал мөнхүү сарын арван долооны морин цагт Булган гол дахь түшмэл нар ба, Хүжиртын хүрээний сэргийлэн суугаа цэргийг захирах тайж Данзан нарын газраас удаа дараа өргөсөн бичгийн дотор хасаг ардын урьд хожид дээрэмдсэн мал юм маш үлэмжийн дээр сая бас Хойт Сэнхэр голд байсан ардад хасгийн цэрэг давхин хүрч ирээд бүгд наян илүү өрхийг дайлан сөнөөлж далан илүү хүний амийг хохируулаад тэдний гэр мал хогшил хөрөнгийг нэгмөсөн авч явсан бөгөөд, өчүүхэн түшмэл цэрэг бид хэдий хүчин чармайн зүтгэж хамгаалан харгалзахыг эрхэлзэвч хасгийн хүн маш олон учир арга мохож гашуун зовуурийг ... бэрх хүлээж бүрмөсөн гацагдан сарнисны тулд, уламжлан зохих газруудад өргөж нэн даруй сахин харгалзуулж ажаамуу хэмээн мэдүүлэн иржээ.

Мунхагдан хянаваас, энэ мэт тэрслэнгүү хасгуудын ардын амийг хохируулан хогшил хөрөнгийг булааж өчнөөн үл хүлицэх гашууныг хүргэн гацагдуулсан нь даанч хорсолтой хэмээгч байтугай мөн одоогоос эхлэн амин биеийг хамгаалж Очирдара богд эзэн хааны өршөөл соёлд шүтэж алба залгамжлан амийг зуухад үнэхээр бэрх болсон амуй. Хэрвээ манай Монгол улсаас их цэргийг дайчлан мордуулж тэрсүүд хасаг ардыг дайлан сөнөөлөхгүй бөгөөс монголын хязгаар дахь шавь боолчуудын үр үндсийг бүрнээр таслан сөнөөлөх нь магад. Ер чимилхийлэн мөдүүлж хэрэгт урлан дурлаж газаргүй үнэн учрыг тодорхойлон гаргаж олдвоос хамаарсан чуулганы дарга засаг улсад туслагч гүн танаа өргөн мэдүүлж гуйх нь, уламжлан зохих газраа суусан жанжин сайдууд танаа довтолгон явуулж өдгөө даруй их цэргийг дайчлан мордуулж хасаг ардыг нэгмөсөн дайлан сөнөөлж шашин үндсээ бататгах ба, зах хязгаар дахь аймаг хошууны ардын амин биеийг хамгаалан харгалзуулхыг мөргөн гуйья. Үүний тул өргөв.

Олноо өргөгдсний гуравдугаар он долоон сарын арван долоондоо [18.8.1913] нохой цаг.

**АЛТАЙ УРИАНХАЙН СУЛ САЙД ГҮН БАЛДАНДОРЖООС ХАРЬЯТ  
ХОШУУГ ХАСАГ ХУЛГАЙ НАР ДЭЭРЭМДЭН, АМЬ ЗУУЛ ҮЙЛДЭЖ  
ЧАДАХГҮЙ БОЛСОН БА БИЕ ӨВЧТӨЙ БӨГӨӨД ТӨЛӨӨ ХҮН  
ОДУУЛСАН ХЭМЭЭХ ЗЭРЭГ УЧИРЫГ ГАРГАЖ АЛБА ЗҮЙЛИЙГ  
ХӨНГӨДГӨН ХҮМҮҮЖҮҮЛХИЙГ ГҮЙН ӨРГӨСӨН ХЭРЭГ<sup>53</sup>**

Дэс түшмэл Дагвасамбуу үзэв.

Түшмэл Сүрэн үзэв.

Түшмэл Норов.

Баруун хязгаарын байцаан үзэж илбэн тохинуулах  
сайд түшээ гүн Со.

Хавсран туслах сайд эрх чин ван Тү.

*шиний хоёроо*

*Хорин зургаан*

*өргөх бичиг*

Дөрвөдийн Сайн заяат баруун гарын үнэн зоригт хан аймгийн Алтай Урианхайн сул сайд Дархан засаг гүн Балдандоржийн бичиг.

Зарлигаар зарсан Баруун хязгаарыг байцаан үзэж, илбэн тохинуулах сайд Цэргийн хэргийг бүгд захиран шийдгэгч яамны дэд сайд, Түшээт хан аймгийн цэргийг захирагч жанжин улсын түшээ гүн, Баруун хязгаарын байцаан үзэж илбэн тохинуулах хэргийг хавсран туслах сайд, Дөрвөдийн зүүн гарын бат ерөөлт төгс хөлөг Далай хан аймгийн чуулган дарга эрх засаг хошой чин ван нар танаа өргөв.

Өргөн мэдүүлэх учир.

Өдгөө өршөөлт сайдууд танай газраас сурган тушаасан хэргийн бичгийн дотор бидний Очирдара багш богд эзэн шавь боолчуудыгаа зүйл зүйлээр өршөөн хүмүүжүүлж бүхийн дотор танай хязгаар дахь шавь боолчуудыг хэтэрхий өршөөн эл зовлон зүдгүүр болсон хэрэг бий болвоос байцаан үзэж илбэн тохинуулж газар орны байдал олны санаанд нийлүүлэн амар тайван болгогтун хэмээн тусгайлан зарлиг өуулгаж сайд бид нар зарсны тулд одоо танай хошуунд зовлон зүдгүүр чирэгдэл болж бэрхшээл олны санаа алдсан хэрэг учир бий үгүйг тодорхойлон гаргаж хэрвээ бий аваас ятган тогтнуулж яаравчилан мэдүүлэн ирүүлээд гүйцэтгэн шийтгүүлж тэнгрийн ёсыг дагаж хүлээн богд эзний өршөөл соёлыг шүтэн нам гүм суун амар жимэрээр аж төрөгдөн хэмээх зэрэг сурган ухуулсан үүнд мунхагдан санаваас өчүүхэн гүн Балдандорж би доорд захирсан олон ардыг дагалдуулан авч Чин улсын гэмт засгаас ангижран салж тулгар байгуулсан өөрийн монголын төрд дагаар орсноос янагш наран гэрэлт, түмэн наст богд эзний өндөр зузаан авралд шүтэн залбирч улс төрийн хүнд хишгийг хүртэж эрхэм чухал албыг хүчин зүтгэн дагнаж доорд олон ардыг сайнд улируулахыг хичээн газар орныг сахиж суусаар боловч ойр хэдэн жилээс янагш

<sup>53</sup> МУУТА.А-141.Д-1.Хн-74. Н-2.



ган зуд тохиолдож аливаа зүйлийн мал үлэмж хохирсны дээр хасаг ард дайлан дээрэмдэж өрх хөрөнгийг бүрэлгэн сүйтгэх ба хүний амийг алан сөнөөх мал хогшилыг уулгалан дээрэмдсэн хэргийг үүний урьд зохих газруудад мэдүүлсээр бөгөөд одоо хир олон тооны хулгай хүн бүлэглэн ирж буугаар буудаж адуу тэмээний зэрэг малыг дээрэмдэн булааж амар товтухуй суулгахгүйд хавчигдан шахагдаж шим өнтэй газарт мал тэжээврийг адуулах ба, тариа тарих гөрөөс гөрөөлөх зэргээр амь зуун ашиг үйлдэж чадахгүй чинээ хүчин нэн мохож ядуурсан нь чин үнэн тулд эм бэрх зүдгүүрээ бие тулж сайдууд танаа бараалхаж гүйцэтгэн мэдүүлье хэмээвч өчүүхэн биед хуучин үгдэрсэн бөөр нурууны өвчин бий бөгөөд мирь унаж холчлон явж чадашгүй тул дэд да лам Лувсанжанцан түшмэл нарыг төлөө томилон зарж бараалхан одуулсан бөлгөө. Иймийн тул үүнийг өршөөлт сайдууд танаа өргөн мэдүүлээд гуйх нь нэвтэрхийлэл толилж энэ мэтээр гацагдан (гачигдан) ядуурч сарнин тархахын туйлд хүрсэн ядуу нэгэн хошууг яахин авран санаж алба зүйлийг хөнгөдгөн дагнуулж аливаад олж хүмүүжин амь биеийг хамгаалан аж төрүүлэх нь сайдуд танай хэтэрхий өршөөлөөс гармой. Үүний тул өргөв.

Олноо өргөгдсөний дөрөвдүүгээр он долоон сарын хорин тавнаа [14.9.1914].

Олноо өргөгдсөний дөрөвдүүгээр он найман сарын хоёрт [21.9.1914].

#### Ашигласан номзүй

Bao Bin 包宾, 2013, *Qingdai zhi Mingguo chuqi Aletai diqu xingzheng guishu yanbian yanjiu* 清代至民国初期阿勒泰地区行政归属演变研究. Xinjiang daxue 新疆大学. 研究生学位论文. Магистрын зэргийн нийтлэгдээгүй төгсөх ажил.

Humphrey, Caroline – Hürrelbaatar Ujeed, 2013, *A Monastery in Time: The Making of Mongolian Buddhism*. The University of Chicago Press, Chicago and London.

*Kebuduo shi yi* 科布多事宜, 1970. Fuyun deng ji 富俊等輯. Zhongguo fangzhi congshu – Sai bei difang – di 42 hao 中國方志叢書 – 塞北地方 – 第四二號. Chengwen chubanshe 成文出版社, Taipei 台北.

Srba, Ondřej – Gegeenhas, 2011, “Nomc’ Bayandeleg (1891–1967): The oral history of a mysterious hermit from Mo’nhhairhan”. In: *Mongolo-Tibetica Pragensia* '11. Ethno-linguistics, Sociolinguistics, Religion and Culture 4/2. Charles University in Prague, Prague, x. 69-91.

Vansina, Jan, 1985, *Oral Tradition as History*. The University of Wisconsin Press, Madison.

*Алтайн Урианхайн угсаатны зүй*, 2014, Ерөнхий редактор Г. Золбаяр, хариуцлагтай редактор М. Ганболд. ШУА-ийн харьяа Баян-Өлгий аймаг дахь нийгэм эдийн засгийн судалгааны төв, Улаанбаатар.

Аюуш, Д. – Ядамжав, Д., 2006, *Алтайн Саруул гүний хошууны Урианхайчууд*. Улаанбаатар.

Бөхөө, Ц., 2007, *Түүх бүтээлцсэн ард түмэн минь*. Мөнххайрхан сум.

Ганболд, М., 2006, Алтайн Урианхайн баруун гарын хошууны ноён Чүлтэм да лам (намтарт холбогдох зарим мэдээ). In: *Түүхийн товчоон*. Том III, Fasc. 9, s. 75-80. Ховд их сургууль Түүхийн тэнхим, Улаанбаатар.

Ганболд, Орьяс Мөнгөнхүүгийн, 2014, Алтайн Урианхайн баруун гарын хошууны ноён Чүлтэм да лам (1886-1942). In: *Бүтээлийн чуулган, Цуврал No. Ховд Их Сургууль, Улаанбаатар*, х. 21-29.

Гантулга, Ц., 2000, *Алтайн Урианхайчууд*. Улаанбаатар.

Гонгор, Д., 2006, *Ховдийн хураангуй түүх*. Тод номын гэрэл төв, Улаанбаатар.

Дулам, С., 2009, *Монгол домог зүйн дүр*. Битпресс, Улаанбаатар.

Жаргалсайхан, Б., 2012, Долоон хошуу Урианхайн Баруун амбаны Дархан Бэйсийн хошууны ноён, да лам Самбуу овогтой Чүлтэмийн намтар түүхээс. In: *Ойрад судлал: Ойрад Монголын түүх, соёлын зүтгэлтнүүд*. Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Ховд Их Сургууль, Улаанбаатар, х. 58-68.

Камимура, Акира, 2015, *Алтай Урианхайн долоон хошууны газрын зургийн тухай*. In: *Монголын газрын зураг, газрын нэр судлал*. Улаанбаатар, х. 100-120.

Катуу, Чорос Балчигийн, 2011, *Монгол Урианхайн аман зохиол*. МУ ШУАХ, Хэл зохиолын хүрээлэн, Улаанбаатар.

*Ойрад монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд II*, 2001. Эмхтгэж, ... кирилл бичигт буулган, тайлбар хийсэн На. Сүхбаатар. МУИС, Түүхийн тэнхим, Улаанбаатар.

Пунцагдорж, Бүүвэйн, 1990, *Алтайн Урианхайн аман зохиолын цоморлиг*. Өлгий.

Пунцагдорж, Бүүвэйн – Сайнбилэг, П., 1999, *Алтайн Урианхайн баруун бээсийн хошууны тайлбар толь*. Хянан засамжилсан проф. П. Увш. Улаанбаатар.

Сүхбаатар, Н. - Бямбажав, Х. (эмхэтгэсэн), 2015, *Алтайн урианхайн түүх соёлын судалгаа*. Bibliotheca Oiratca, vol. LI. Тод номын гэрэл төв, Улаанбаатар.





**СОЁЛ, УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ  
СОЁЛ, УРЛАГ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН**

---

**JOURNAL OF ARTS AND CULTURAL STUDIES  
IN MONGOLIA**

---

**Tomus XIX**

**Fasciculus 1-24**

**МОНГОЛЫН СОЁЛ,  
УРЛАГ СУДЛАЛ**

**БОТЬ XIX**

**УЛААНБААТАР  
2016**

**РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**

Сонинтогос Э. СУИС-ийн захирал, доктор (Ph.D), профессор

**НАРИЙН БИЧГИЙН ДАРГА**

Баатархүү Б. СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D)

**ГИШҮҮД**

Алтанцэцэг Ч. СУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, доктор (Sc.D), профессор  
Даваасүрэн Д. СУИС-ийн эрдэм шинжилгээ, инновацийн газрын дарга, доктор (Ph.D), дэд профессор  
Батсуурь Ж. СУИС-ийн Соёлын сургуулийн судалгааны профессорын багийн тэргүүлэх профессор, доктор (Sc.D)  
Чулуунбаатар Г. СУИС-ийн Соёлын сургуулийн судалгааны профессорын багийн тэргүүлэх профессор, доктор (Sc.D), академич  
Дулам С. СУИС-ийн Бүжгийн урлагийн сургуулийн судалгааны профессорын багийн тэргүүлэх профессор, доктор (Sc.D)  
Жанцанноров Н. СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн судалгааны профессорын багийн тэргүүлэх профессор, доктор (Ph.D)  
Ганхуяг Н. СУИС-ийн Театрын урлагийн сургуулийн судалгааны профессорын багийн тэргүүлэх профессор, доктор (Ph.D)  
Соронзонболд С. СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн судалгааны профессорын багийн тэргүүлэх профессор, доктор (Ph.D)  
Энхдаваа Д. СУИС-ийн Дүрслэх, дизайн урлагийн сургуулийн судалгааны профессорын багийн тэргүүлэх профессор, доктор (Ph.D)

Дугаарыг эрхэлсэн: Б.Баатархүү  
Х.Мэндсайхан

Монгол Улсын Соёл, Урлагийн их сургууль, Соёл, Урлаг судлалын хүрээлэн  
Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, СУИС-ийн хичээлийн II байр  
Tel: 70137055  
Fax: 976-11-70137055  
E-mail: huum999@yahoo.com

**МОНГОЛЫН СОЁЛ, УРЛАГ СУДЛАЛ. БОТЬ XIX  
УЛААНБААТАР 2016.**

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Оюун  
Хэвлэлийн хуудас: 29.0 х.х.  
Хэвлэсэн үйлдвэр: "АДМОН ПРИНТ" ХХК  
Хэвлэсэн тоо: 300 хувь  
Цаасны хэмжээ: 176x250 1/10  
Хэвлэлтэд: 2016 оны 7 сар

**ISSN 2310-9114**

© Монгол Улсын Соёл, Урлагийн их сургууль, Соёл, Урлаг судлалын хүрээлэн, 2016  
Printed in Mongolia

**СОЁЛ С**

**Б.Баярс**

Алта  
эксп

**Б.Пунса**

Арды

**Д.Ганто**

Аяла

Мон

**М.Ганб**

Хото

**Д.Нараг**

ШУТ

**Б.Өмир**

Мон

**Лю.Хай**

Кида

**Н.Хатаг**

Эрдэ

**Adrienn**

Түвд

бари

**Elisa Ko**

Үнэ

Мон

**Г.Алтан**

"Мо

үзэл

**М.Лхам**

Дилс

**Г.Ариун**

Мон

холб

**УРЛАГ СУДЛАЛ**

**С.Дулам**

Тэнгэрийн хүүхдүүдийн бүжиг, тэдгээрийн танивар  
дохиог тайлах нь ..... 163

**Да.Эрдэнэбат**

Орчин үеийн Монголын театрын хөгжлийн асуудалд ..... 182

**Б.Дэлгэрмаа**

Монгол дахь гоо зүйн сургалт, судалгаа ..... 211

**Г.Оюунтуяа**

Хөгжмийн хамтлаг болон хөгжмийн сургалтын электрон  
үйл ажиллагаа ..... 218

**Ж.Эрдэнэхорлоо**

Ц.Сэвжидийн уран бүтээл бий биелгээтэй холбогдох нь ..... 221

**ТҮҮХ, ХЭЛ ШИНЖЛЭЛ**

**Ч.Баасанжаргал**

Хэл шинжлэл дэх хүний сэтгэлгээний онцлог ..... 228

**Г.Золбаяр**

Тува хэлэн дэх хүүхдэд хамаатай бүлэг үгийн тухайд ..... 235

**Д.Одсүрэн**

Хүннүгийн угсаа гарвалын түүх бичлэгийн зарим асуудалд ..... 238

**Ондршей Срба**

Алтайн Урианхайн баруун амбан буюу дархан гүн Балдандоржийн  
түүх болон аман уламжлалын дүр ..... 251

**НАМТАР СУДЛАЛ**

**Ж.Болдбаатар**

Хуурч Дондогжалбаагийн Түдэв ..... 273

**Х.Мэндсайхан**

Хөгжмийн удирдаач Тогоочийн Балданцэрэн улс төрийн  
хилс хэрэгт хэлмэгдсэн нь ..... 286

CULT  
Bayar  
Fie  
Punsal  
Pol  
Gantu  
The  
Gle  
Ganbo  
Sor  
Narant  
Ref  
Umirb  
Tyr  
Munkh  
Stu  
Khatan  
Am  
Tra  
Adrien  
The  
and  
Elisa K  
Val  
Rec  
Altansu  
Tow  
Secr  
Lkhamj  
Reli  
Ariuntu  
Fron  
of M



CONTENTS

CULTURAL STUDIES

**Bayarsaikhan B., Baatarkhuu B.**

Field Expeditions and Explorations on the Tuva people in Altai Region ..... 7

**Punsaldulam B.**

Policy on Culture in Period of Peoples' Government and Its Features ..... 15

**Gantumur D.**

The tourist culture in the development of tourism destination:  
Glocalization process of tourism in Mongolia ..... 25

**Ganbold M., Teroe Moe**

Some Observations on Khoton Peoples' Sacraments ..... 38

**Narantsatsral D.**

Reform of Cultural Studies Curriculum in MUST ..... 45

**Umirbek B., Jargalsaikhan B.**

Types of Felt Dwelling for Mongolian Kazakh People ..... 54

**Munkhtsetseg B., Lu Hailan**

Study on Types and Forms of Collar for Khitan Deel ..... 69

**Khatanbaatar N.**

Amulets, Idols and Tsam Procession in Erdene Zuu Monastery:  
Traditions and Reforms (Between XVI-XIX Centuries) ..... 80

**Adrienn Cece**

The role of Arts, Crafts and Statue making in Traditional Tibetan  
and Mongolian Societies ..... 99

**Elisa Kohlarity**

Value and Respect Reconsidered: Juxtaposing the Remote and  
Recent Past in Mongolia ..... 111

**Altansukh G.**

Towards an Issue of Viewpoint "Sky Enthroned King" in  
Secret History of Mongolia ..... 121

**Lkhamjav M.**

Religious Activities of Dilov Khutagt Jamsranjav B. .... 136

**Ariuntuya G.**

From Some Historical Items Used during First Diplomatic Visit  
of Mongolia to Russian Empire ..... 155

**ART STUDIES**

**Dulam S.**  
Encoding "Dance of Sky Children" ..... 163

**Erdenebat D.**  
Towards Some Issues of Theatre Development in Mongolia ..... 182

**Delgermaa B.**  
Academic Training and Research on Aesthetics in Mongolia ..... 211

**Oyuntuya G.**  
Online Activities Club of Music Education and Music Group ..... 218

**Erdenekhорloo J.**  
The relationship between works by Ts. Sevid and biyelgee,  
the western mongolian dance ..... 221

**HISTORY AND LINGUISTICS**

**Baasanjargal Ch.**  
Mentality and Behavior Standards in Languages ..... 228

**Zolbayar G.**  
On a Group of Words and Expressions in Tuva Language Related  
to Child ..... 235

**Odsuren D.**  
Towards Some Issues of Historiography on Hun State Origin ..... 238

**Ondrej Srba**  
Darhan Gun Baldandorj, Governor of the right banner of Altai urianhais:  
Archive documents and oral tradition ..... 251

**BIOGRAPHY STUDY**

**Boldbaatar J.**  
Tudev Dondogjalbaa ..... 273

**Mendsaikhan D.**  
Study on Political Repression of Baldantseren Togooch ..... 286

**ЖУРНАЛ  
ЭНЭ**

**Баярс  
Баатар**

**Abstract**  
Now the  
province  
Ulgi, K  
The Tu  
Ola me  
autono  
people i  
The stu  
Howeve  
Tuva p  
when th  
Erica T  
Univers  
Tsengel  
the exp  
2 mont  
expedit  
Republ  
Altai m  
of scien

**Key**

Эдү  
Алтайн  
Туваги

\* Баярс  
эдийн  
\*\* Баата